


СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ



ДУГААР 2024 / 2

СЭТҮҮЭГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
СОНГУУЛЬ
2024



Монгол Улсын Их Хурлын
СОНГУУЛЬ

2024

САНАЛ АВАХ ӨДӨР

VI.28



www.m-election.mn

YouTube GECMongolia

Монгол Улсын Сонгуулийн
ерөнхий хороо





РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ЭРХЛЭГЧ

Б.Цэцэгдэлгэр

Референт-хэвлэлийн төлөөлөгч

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.Ариунболд

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн мэргэжилтэн

ЗӨВЛӨХ

Ж.Амарсанаа

Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор

ГИШҮҮД

П.Алтанчимэг

Мэдээллийн технологийн төвийн ахлах референт

Ш.Сүхбаатар

Хууль зүйн доктор, судлаач

С.Оюунтуяа

"Сонгогчдын боловсрол төв" ТББ-ын гүйцэтгэх захирал

Ч.Сайнсанаа

"Чимид сан"-ийн тэргүүн

З.Бадмаараг

Сэтгүүлч

С.Уянга

"Сонгуулийн боловсрол" клубийн удирдах зөвлөлийн дарга

@Бүтээлийн зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан тул олшруулахыг хориглоно.

АГУУЛГА

4

1.ДУГААРЫН ЗОЧИН

- П.Дэлгэрнаран: Төрийн эрх барих дээд байгууллагад төлөөллөө сонгох эрхээ эдлэхдээ хариуцлагатай хандана гэдэгт итгэж байна

8

2. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

- Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог, мандатын тоо, нутаг дэвсгэр, төв

10

3. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА

- Сонгуулийн сурталчилгаа
- Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах журмын зохицуулалт
- Цахим орчин ашиглан сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журмын зохицуулалт
- Сурталчилгааны зурагт самбар

19

4. МӨРИЙН ХӨТӨЛБӨР

- Б.Бундхорол: Мөрийн хөтөлбөр нь хэрэгжих эрх зүйн болоод санхүүгийн боломжтой, бодлогын цогц шийдэл байх ёстой
- С.Оюунтуяа: Мөрийн хөтөлбөр бол "сонгогчтой байгуулж буй гэрээ" юм

24

5. СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ

- Н.Наранцэцэг: Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ шалгах үүрэгтэй
- Сонгогчдын нэрийн жагсаалтаас юу мэдэх вэ?

29

6.ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ

- "Хариуцлагатай сонгогч" сонгуульд оролцож буй улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг судалж байж саналаа өгдөг
- Н.Булгамаа: Иргэний сонгох эрхийг хангахаар уул уурхайн компаниудтай хамтран ажиллаж байна
- П.Алтанчимэг: Гадаадад байгаа иргэд санал өгөхөө дипломат төлөөлөгчийн газартаа мэдэгдэнэ
- Гадаад улсад байгаа иргэд саналаа өгнө...
- Та хариуцлагатай сонгогч

43

7.СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛД

- Б.Цолмонбаяр: Холимог тогтолцоонд сонгогчдын санал хамгийн бага гээгддэг
- Залуу сонгогчдын боловсролд зориулсан бүтээлийн ХАКАТОН
- Залуус саналаа өгнө...

48

8.ХЯНАЛТ

- Сонгуулийн автоматжуулсан системийн баталгаажуулалт, хяналт
- Сонгогч саналаа өгснийг илэрхийлэх бэхэн тэмдэглэгээ хийх заавар
- С.Энхжаргал: Санал тоолох төхөөрөмжийн систем олон мөр үлдээдэг сайн дизайнтай гэж гадаадын ажиглагчид дүгнэдэг
- Саналын хуудсыг 100 хувь гараар тоолж, хяналтын тооллого хийнэ

56

9. СОНГУУЛЬ ДЭЛХИЙ ДАХИНД

- БНСУ-ын парламентын сонгуулийн эргэн тойронд ...



П.ДЭЛГЭРНАРАН: ТӨРИЙН ЭРХ БАРИХ ДЭЭД БАЙГУУЛЛАГАД ТӨЛӨӨЛЛӨӨ СОНГОХ ЭРХЭЭ ЭДЛЭХДЭЭ ХАРИУЦЛАГАТАЙ ХАНДАНА ГЭДЭГТ ИТГЭЖ БАЙНА

*Монгол Улсын Сонгуулийн
ерөнхий хорооны дарга
П.Дэлгэрнарантай ярилцлаа.*

“Монгол Улсын Их Хурал анх удаа 126 гишүүнтэй болно гэдэг утгаараа энэ удаагийн сонгууль онцлогтой. Сонгуулийн зохион байгуулалт ч өмнөх сонгуулиудаас өөр байгаа юу?”

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно” гэж өөрчлөн найруулсан бөгөөд 2024 оны нэгдүгээр сарын 1-ээс дагаж мөрдөж байгаа.

Улсын Их Хурлын тогтоолоор аймгийг 7, нийслэлийг 6 тойрог болгож, сонгуулийн 13 тойрог байгуулсан. Мөн санал авах өдрийг 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдөр, гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдрийн 6 дугаар сарын 20, 21, 22, 23-ны өдөр байхаар тогтоосон.

“Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах хуваарь”-ийг Сонгуулийн ерөнхий хороо өнгөрсөн 1 дүгээр сарын 9-ний өдөр баталсан. Хуваарийн дагуу бэлтгэл ажил үргэлжилж байна. Сонгуулийн ерөнхий хорооны хуралдаанаар аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнийг баталсан. Мөн гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэгтэй Төв комисс байгууллаа.

“Сонгуулийн хороонд “намынхаа хүнийг шургуулна”, “тэдний намынхнаар хороог бүрдүүлчихлээ”, “намын хүнээ оруулснаас үүдээд сонгуулийн маргаан гарна” гэхчлэн явган яриа тасардаггүй.

“Нэгдүгээрт, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдыг www.e-election.mn системээр нээлттэй бүртгэж, цахим сургалтад хамруулж, сорил авсны үндсэн дээр гэрчилгээ олгож байгаа. Төрийн захиргаа, үйлчилгээний

албан хаагчдад сонгуулийн хороодод ажиллах эрх нь бүрэн нээлттэйгээс гадна аль хороонд ажиллах хүсэлтэй байгаагаас системд бүртгүүлнэ.

Хоёрдугаарт, Сонгуулийн ерөнхий хороо аймаг, нийслэлийн сонгуулийн хороог байгуулахдаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн саналыг харгалздаг болохоос яг тэр чигээр нь баталдаггүй. Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороодын даргаар тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дарга, эсхүл Тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгч ажиллана. Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд нь тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны төлөөлөл, цагдаагийн болон улсын бүртгэл эрхэлсэн байгууллагын дарга орно. Үүнээс гадна санхүүгийн тайлан тооцоо гаргах, архивын нэгж бүрдүүлэх хэмжээний мэргэжилтэн байна уу зэрэг шалгуур тавьж байж бүрэлдэхүүний бусад гишүүнийг томилдог.

-Ер нь сонгуулийн хороод будилаан хутгаад, үймүүлээд байх эрх мэдэлтэй юм уу?

-Зохион байгуулалтын ажил л хийдэг. Нам, эвсэл, нэр дэвшигчийг бүртгэхгүй. Зөрчил, маргаан шийдвэрлэхгүй шүү дээ. Тухайлбал, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тухайн нутаг дэвсгэрийнхээ төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, техник хэрэгсэл, саналын хуудсыг хүргүүлэх, хадгалах хяналт тавих, санал хураалтын дүн, холбогдох баримт бичгийг нэгтгэж Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх зэрэг зохион байгуулалтын ажил хийдэг.

Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах ажилтны үнэмлэх олгоно. Түүнчлэн нэр дэвшигчийн менежер, шадар туслагчийн үнэмлэхийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, ухуулагчийн үнэмлэхийг сум, дүүргийн сонгуулийн хорооноос авна.

Хуульчлаад өгчихсөн энэ мэт үүргээ хэрэгжүүлэхэд будилаан хутгаад, үймүүлээд байх боломжгүй.

-Хоёр, гурван аймаг нийлээд нэг тойрог болсон. Аймгийн сонгуулийн хороод хэрхэн уялдаж ажиллах вэ?

-Тойргийн төв буюу хамгийн олон сонгогчтой аймаг, дүүргийн сонгуулийн хороо нь тухайн тойрог дахь зохион байгуулалтын ажлыг хариуцах юм.

-Үндэсний аудитын газарт 27 нам, хоёр эвсэл мөрийн хөтөлбөрөө хүргүүлсэн. Улсын дээд шүүхэд бүртгэлтэй намуудын 80 гаруй хувь нь сонгуульд оролцох бололтой. Нам бүрээс мандатын тоогоор нэр дэвшүүлнэ, үүн дээр бие даан нэр дэвшигчид нэмэгдэнэ гэвэл хоёр мянга хол давсан хүн өрсөлдөх нь ээ.

-Нам, эвсэл сонгуульд оролцох хүсэлтээ дөрөвдүгээр сарын 26-28-ны өдөр Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ. Сонгуулийн ерөнхий хороо хүсэлтийг хүлээн авснаас хойш тав хоногийн дотор шийдвэр гаргах юм. Улмаар нам, эвслээс болон бие даан нэр дэвшигчдийн баримт бичгийг тавдугаар сарын 25-ны дотор ирүүлнэ. Сонгуулийн ерөнхий хороо

нэр дэвшигчийг бүртгэх эсэхийг шийдвэрлэх, дахин бүртгүүлэх, нөхөн нэр дэвшүүлэх зэрэг процедур явсаар зургаадугаар сарын 10-ны өдөр нэр дэвшигчийн үнэмлэх олгож, нийтэд мэдээлнэ. Ингэснээр таны таамаглаж асуугаад байгаа нам, эвсэл, нэр дэвшигчдийн тоо тодорхой болох юм.

-Саналын хуудсыг л төсөөлөхөд 10 мандаттай тойрогт 29 нам, эвсэл болон 300 орчим нэр дэвшигч бичигдэх магадлалтай байна. Нэлээн урт байх уу, эсвэл хоёр, гурван хэсэг байх уу?

-Сонгуулийн холимог тогтолцоо, томсгосон тойрогтой учраас саналын хуудасны дундаж хэмжээ томорч байгаа. Саналын хуудас тойрогт нэр дэвшигчид өгсөн санал тэмдэглэх, нам, эвсэлд өгсөн санал тэмдэглэх хоёр хэсэгтэй байх юм. Энэ хоёр хэсгийг тэмдэглэх тус, тусдаа хуудас байх уу, нэг хуудас байх уу гэдэг хувилбаруудыг гаргаад ажиллаж байна. Саналын хуудасны хэмжээнээс илүү анхаарах асуудал нь сонгогч мандатын тоотой тэнцүү нэр дэвшигчид заавал санал өгч тэмдэглэх ёстой. Илүү, эсвэл дутуу тэмдэглэвэл санал хүчингүйд тооцогдоно. Тиймээс сонгогчид маш хариуцлагатай, няхуур байх шаардлагатай гэсэн үг.

“

**ТӨЛӨӨЛӨГЧӨӨРӨӨ УЛАМЖИЛЖ
ТӨРИЙН ЭРХ БАРИХ НЬ ИРГЭНИЙ
ҮНДСЭН ЭРХ. ҮҮНИЙГ ДАГАСАН
ХАРИУЦЛАГА. ТӨРИЙН ЭРХ БАРИХ
ДЭЭД БАЙГУУЛЛАГАД ТӨЛӨӨЛӨӨ
СОНГОХ ЭРХЭЭ ЭДЛЭХДЭЭ
ХАРИУЦЛАГАТАЙ ХАНДАНА ГЭДЭГТ
ИТГЭЖ БАЙНА.**

-Олон нам, эвсэл, нэр дэвшигчийг жагсаасан хуудас дээр тэмдэглэгээ хийхэд сандрах, алдаа гаргах эрсдэл гарах болов уу?

-Төлөөлөгчөөрөө уламжилж төрийн эрх барих нь иргэний үндсэн эрх. Үүнийг дагасан хариуцлага. Төрийн эрх барих дээд байгууллагад төлөөллөө сонгох эрхээ эдлэхдээ хариуцлагатай хандана гэдэгт итгэж байна.

Сонгуульд оролцох, саналын хуудас бөглөх заавар, гарын авлагыг айл бүрд өгөхөөр бэлтгэж байгаа. Нам, эвсэл, нэр дэвшигчдийн нэрийг санал өгөх өдөр л гэнэт харна гэж байхгүй. Сурталчилгааны хугацаа гэж байна. Нам, эвсэл, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, бодлого, зорилттой нь сайтар танилцаж, сонголтоо хийххээд санал өгөх байранд очих нь тодорхой.

-Сонгуулийн хэсэг буюу сонгогчдын саналаа очиж байршил тодорхой болчихсон уу. Нэг хэсэгт хэд орчим сонгогч ноогдож байгаа бол?

-Сонгогчдын санал авч, тоолох зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал сонгуулийн хэсэг байгуулж, нутаг дэвсгэрийг зарладаг. Хэсэг нь суманд 2000-аас дээшгүй, аймгийн төв болон дүүрэгт 3000-аас дээшгүй сонгогчтой байхаар хуульчилсан. Энэ удаагийн сонгуулийн онцлог, санал өгөх нэгж хугацааг харгалзаж нэг хэсэгт ноогдох сонгогчийн тоог 2000-д хүргэхгүй байх чиглэлийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өгсөн. Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуультай харьцуулахад хэсгийн тоо 100 гаруйгаар нэмэгдсэн байна. Нэг хэсэгт ноогдох дундаж сонгогчийн тоо нийслэлд 2100, аймагт 680 орчим байгаа.

Онцгой нөхцөл байдлын улмаас хэсэг тусгаарлах,

нэгтгэх, шинээр байгуулах асуудлыг Сонгуулийн ерөнхий хорооны зөвшөөрлөөр шийдвэрлэж болдог. Тухайлбал, Ховд, Дорнод аймгуудаас цэргийн ангийг түшиглээд хэсэг шинээр байгуулах, зарим сум айлууд нь төвөөс хол зусланд гарчихдаг, гол ус хааж боогддог шалтгаанаар 200-аас доош сонгогчтой хэсгийг хэвээр үлдээх зэрэг хүсэлтүүд ирүүлсэн. Энэ мэт хүсэлтийг Сонгуулийн ерөнхий хорооны хуралдаанаар хэлэлцэж, шийдвэрлэсэн.

-Нэг сонгогч санал өгөх хугацааг хэрхэн тооцож байгаа вэ. 07:00-22:00 хүртэл сонгогчид саналаа өгч амжихгүй байх эрсдэл бий юү?

-Саналын хуудаст бичигдэх нам, эвсэл, нэр дэвшигчдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой сонгогч санал тэмдэглэх, санал тоолох төхөөрөмжид уншуулахад зарцуулах хугацаа яах аргагүй уртсаж байгаа. Тиймээс өмнө хэлсэнчлэн хэсэгт ноогдох сонгогчийн тоог аль болох цөөн байхаар тогтоосон.

Санал авах, тоолох ажиллагааг зохион байгуулахад сонгогчдод хүндрэл учруулахгүй, дараалал үүсгэхгүй байхаар санал авах байрыг аль болох том байхаар бэлтгэх, бүхээг нэмэх зэрэг зохион байгуулалтыг хийж байна.

-Өмнөх сонгуультай харьцуулахад сонгогчийн тоо хэр зэрэг нэмэгдсэн бэ. Сонгогчдын ирц, идэвхийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрхэн ажиллаж байгаа бол?

-Сонгуулийн насны хүний тоо өнгөрсөн гуравдугаар сарын байдлаар 2,230,101 байна. Сонгуульд оролцох нь улсынхаа өмнө хүлээсэн хариуцлага гэдгийг дахин хэлье. Сонгох эрхээ эдлэх, төлөөллөөрөө уламжилж төрийн эрх барих хариуцлагаа хэрэгжүүлэх сонгуулийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Сонгуулийн ерөнхий хороо олон

СОНГУУЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ СИСТЕМ

Сонгуулийн байгууллагын бүтээмж, мэдээлэл солилцооны үр ашгийг нэмэгдүүлэх, олон нийтийг нээлттэй, ил тод мэдээллээр хангана.

УИН-ЫН СУДАЛГААНЫ САН

Нэвтрэх хэсэг

1. Системийн хэрэглэгч

2. Хэрэглэгчийн нэр

3. Нууц үг

Рхуульчилсан? Кетүүл

Нэвтрэх

Дангаар нэвтрэх

Powered by Veritech DSP

нийт, шинэ сонгогчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд, төрийн албан хаагчдад зориулсан олон төрлийн сургалтын хөтөлбөрийн дагуу 7 хоногт 2-3 удаа сургалт зохион байгуулж байна. Энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа.

Үүнээс гадна байнга оршин суух хаягаасаа өөр газар ажилладаг, гадаад улсад байгаа иргэдийнхээ сонгох эрхийг хангах чиглэлээр Хүний эрхийн үндэсний комисстой хамтран төлөвлөгөө гаргаад ажиллаж байна.

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэд бусдын дэмжлэггүйгээр санал авах байранд очиж саналаа өгөх хүндрэлтэй байдаг талаар Хүний эрхийн үндэсний комиссын илтгэлд дурдагдсан байна лээ. Уул уурхайн компаниудад ээлжийн ажил хийдэг хүмүүс сонгуульд оролцож чаддаггүй.

-Санал авах өдөр ажиллаж байгаа сонгогчдод байгууллага нь чөлөө олгож, саналаа өгөх боломжоор хангах үүргийг хуульчилсан.

Байнга оршин суугаа хаягаасаа өөр газар байгаа сонгогчдын олонх нь уул уурхай болон зам тээврийн салбарт ажилладаг. Сонгуулийн ерөнхий хорооны ажилтнууд өнгөрсөн гуравдугаар сард долоон багт хуваагдаж орон нутагт ажиллахдаа Хүний эрхийн үндэсний комиссын ажилтантай хамтран уул уурхайн компаниудад сургалт хийж, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, сонгох эрхээ эдлэх боломжоор хангах талаар удирдлагуудтай нь уулзсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх чиглэлээр сонгуулийн хороодын ажилтнуудыг чадавхуулах, олон нийтэд хүргэж буй зөвлөмж, зааварчилгаа, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сонгуулийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр "Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо"-той санамж бичиг байгуулаад хамтран ажиллаж байгаа.

Олон улсад сайн дурын ажилтнууд сонгуулийн зохион байгуулалтад дэмжлэг үзүүлж ажилладаг. Энэ сайн жишгийг нэвтрүүлж хөгжлийн бэрхшээлтэй иргэд санал авах байр руу орох зэрэгт дэмждэг үзүүлэх сайн дурын ажилтнуудыг ажиллуулах боломжийн талаар ч судалж байна.

-Сонгууль бүрээр л зөрчил яригддаг. Гомдол, зарга байгууллага хооронд дамжиж явсаар сонгууль болоод өнгөрдөг. Энэ удаагийн сонгуулиар зөрчлийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?

-Хуульд тодорхой заасан. Нэг ч зөрчил, хэргийг Сонгуулийн ерөнхий хороо шийдвэрлэхгүй. Сонгуулийн үеийн зөрчлийг цагдаа, тагнуулын байгууллагын эрх бүх албан тушаалтан, татвар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Монгол банк, Улсын бүртгэл, нягтлан бодох, харилцаа холбооны улсын байцаагчид болон шүүх зэрэг есөн байгууллага шалгаж шийдвэрлэнэ.

-Сонгуулийн дүнг түргэн, шуурхай яаж мэдээлэх вэ. Өмнөх сонгуулиар дүнг шууд дамжуулж байсан ч зарим хэсгийн мэдээ цаг алдаж ирэх шиг болсон.

-Монгол Улс өргөн уудаг нутагтай, дэд бүтэц бүх газарт жигд хөгжөөгүй зэрэг бэрхшээл бий. Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар 461 санал авах байрнаас санал хураалтын дүнг зөөвөрлөж дамжуулж байсан. Мэдээллийн төвөөс сүлжээний дэд бүтцийн судалгаа хийхэд одоогоор 200 гаруй хэсгийн хорооны байрлалд үүрэн холбооны сүлжээгүй дүгнэлт гарсан. Тэдгээр хэсэгт "Старлинк" компанийн хиймэл дагуулын үйлчилгээг авч ашиглахаар бэлтгэж байна.

-Гадаад, дотоодын ажиглагчид болон нам, эвсэл олон нийтийн хяналт сонгуулийн зайлшгүй нэг хэсэг. Ажиглах, хянах боломжийг хэр бүрдүүлж байна вэ?

-Сонгуулийн зохион байгуулалт бүрэн нээлттэй. Тухайлбал, санал тоолох төхөөрөмжүүдийг нэг бүрчлэн шалган туршиж баталгаажуулдаг. Энэ үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, нам, эвсэл, нэр дэвшигчид, сэтгүүлчдийн төлөөллийг нээлттэй оролцуулдаг.

Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч болон төрийн бус байгууллага санал авах байранд хоёр хүртэл ажиглагч томилж ажиллуулах эрхтэй. Үүнээс гадна дотоод, гадаадын сэтгүүлчид ч сурвалжлахад бүрэн нээлттэй.

Олон улсын ажиглагч, сэтгүүлчид Монгол Улсын сонгуулийн үйл ажиллагааг дэлхий нийтэд мэдээлж, сурталчлахаас гадна анхаарах асуудлыг тодорхойлдог өндөр ач холбогдолтой. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын Ардчилсан институт, хүний эрхийн газар өөрийн гишүүн орнуудад явуулж байгаа сонгуулийн үйл ажиллагааг өргөн бүрэлдэхүүнтэйгээр ажиглаж, тайлан, зөвлөмжөө гаргадаг. Тэдний зөвлөхүүд гуравдугаар сард манай улсад ажиллаж манайх болон бусад байгууллагын удирдлагуудтай уулзалт хийгээд буцсан. Уулзалтын тайлан, дүгнэлтээ үндэслээд сонгууль ажиглах хүний тоо, цар хүрээгээ тодорхойлдог. Өмнөх сонгуулиудын жишгээр тэднийхээс 300 гаруй ажиглагч ирдэг.

Үүнээс гадна хамтран ажилладаг улс орнууд, олон улсын байгууллагуудад урилга хүргүүлсэн.

Энэ удаагийн сонгуулиар 100 хувь хяналтын тооллого хийнэ. Хяналтын тооллого мөн л бүрэн нээлттэй. Тооллого хийх ажилд саад болохгүйгээр ажиглаж, хэвлэл мэдээллийн байгууллагууд сурвалжилга хийх боломжтой гэсэн үг.

*Ярилцсанд баярлалаа.
Б.Цэцэгдэлгэр*


УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТОЙРОГ, МАНДАТЫН ТОО, НУТАГ ДЭВСГЭР, ТӨВ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1-д “Улсын Их Хурал нэг танхимтай, **НЭГ ЗУУН ХОРИН ЗУРГААН** гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн **ХОЛИМОГ ТОГТОЛЦООГООР** явуулна. Улсын Их Хурлын **ДАЛАН НАЙМАН** гишүүнийг **ОЛНЫГ ТӨЛӨӨЛӨХ, ДӨЧИН НАЙМАН** гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” гэж заасан.

78 гишүүнийг олныг төлөөлөх /мажоритар/ аргаар сонгох нь тухайн тойрогт ногдох мандатын тооноос шалтгаалж сонгогч сонголтоо хийхийг хэлнэ. Жишээ нь, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай аймгууд нь баруун бүсэд хамаарах

2 дугаар тойрог бөгөөд 10 мандаттай байх юм. Сонгогч энэ тойрогт санал өгөх бол дэмжиж буй **10 НЭР ДЭВШИГЧ**ид саналаа өгнө. Илүү эсвэл дутуу бөглөвөл тухайн сонгогчийн саналын хуудас хүчингүй болно.

48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорционал/ аргаар сонгоно гэдэг нь сонгогч зөвхөн нэг нам, эвслийг сонгоно. Өөрөөр хэлбэл, улс төрийн нам нь тойрогт зориулсан бодлого боловсруулж өрсөлдөх бус улсын хэмжээний бодлого боловсруулах үндсэн чиг үүрэгтэй нь холбоотой. Тиймдээ ч улс төрийн нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого



СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООГ
ТАЙЛБАРЛАСАН ШТОРКТОЙ
ТАНИЛЦАНА УУ




дэвшүүлэн сонгуульд оролцдог, хамтын шийдвэр гаргаж, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн гэж хуульчилсан.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 112 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоосон. Уг тогтоолоор Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд 5 бүсэд хамаарах нийт 13 тойргийг тогтоосон.

6 дугаар ТОЙРОГ

7
Мандат



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ
ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТОЙРГИЙН ДУГААР, НУТАГ
ДЭВСГЭР, ТӨВ, ТОЙРОГТ НОГДОХ МАНДАТЫН ТОО**

Тойргийн дугаар	Тойргийн нутаг дэвсгэр	Тойргийн төв	Мандатын тоо
1	Архангай Баянхонгор Өвөрхангай	Өвөрхангай аймгийн Арвайхээр сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	9
2	Говь-Алтай Завхан Увс Ховд	Ховд аймгийн Жаргалант сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	10
3	Баян-Өлгий	Баян-Өлгий аймгийн Өлгий сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	3
4	Булган Орхон Хөвсгөл	Хөвсгөл аймгийн Мөрөн сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	8
5	Дархан-Уул Сэлэнгэ Төв	Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	10
6	Дорнод Сүхбаатар Хэнтий	Дорнод аймгийн Хэрлэн сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	7
7	Говьсүмбэр Дорноговь Дундговь Өмнөговь	Өмнөговь аймгийн Даланзадгад сум, Аймгийн Засаг даргын Тамгын газар	7
8	Баянзүрх	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар	5
9	Баянгол	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар	3
10	Сүхбаатар Чингэлтэй	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар	6
11	Сонгинохайрхан	Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар	5
12	Хан-Уул	Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар	3
13	Багануур Багахангай Налайх	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар	2
Дүн			78

8 дугаар ТОЙРОГ

5
Мандат

Баянзүрх

11 дүгээр ТОЙРОГ

5
Мандат

Сонгинохайрхан

9 дүгээр ТОЙРОГ

3
Мандат

Баянгол

12 дугаар ТОЙРОГ

3
Мандат

Хан-Уул

10 дугаар ТОЙРОГ

6
Мандат

Сүхбаатар
Чингэлтэй

13 дугаар ТОЙРОГ

2
Мандат

Багануур
Багахангай
Налайх

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА



СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААГ ХЭН ХИЙХ ВЭ?

- Сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигч болон түүний менежер, шадар туслагч, ухуулагчаас бусад этгээд сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглоно.
- Төрийн улс төрийн албан хаагч сонгуулийн сурталчилгаанд оролцож болно.



СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААГ ДАРААХ АРГА, ХЭЛБЭРЭЭР ЯВУУЛНА:

- ☑ Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах;
- ☑ Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах;
- ☑ Хуульд өөрөөр заагаагүй бол намын далбааг гудамж, талбайд байрлуулах, таних тэмдэг, уриа ашиглах;
- ☑ Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх;
- ☑ Ухуулах байр ажиллуулах;
- ☑ Радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах;
- ☑ Цахим орчин ашиглах;
- ☑ Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх.
- ☑ Сонгуулийн сурталчилгааны уулзалт, хандивын талаар сонгогчдод зар, урилга явуулсныг сурталчилгааны хэвлэмэл материалд оруулан тооцохгүй. Зар, урилга нь А5 хэмжээнээс илүүгүй байна.
- ☑ Сонгуулийн сурталчилгааны аливаа материалын баруун доод хэсэгт сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар товчлохгүй бичих бөгөөд энэ нь телевизийн нэвтрүүлгийн нийт хугацаанд хамаарна. Радиогийн нэвтрүүлгийн тухайд эхлэл, төгсгөлд нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдана.



СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ЯВЦАД ДАРААХ ҮЙЛДЭЛ ГАРГАХ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХЫГ ХОРИГЛОНО:

- ☒ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа хийх;
- ☒ Зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх;
- ☒ Сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах;
- ☒ Хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаанд ашиглах;
- ☒ Оройн 22:00 цагаас дараа өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд чанга яригч ашиглах;
- ☒ Олон нийтийг хамарсан аливаа шашны зан үйл ашиглах, түүнийг зохион байгуулах, оролцох, ивээн тэтгэх, шашны холбогдолтой эд зүйл тараах.



СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА ХИЙХ ХУГАЦАА

Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсоно. **ТОДРУУЛБАЛ, СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА 2024 ОНЫ 6 ДУГААР САРЫН 10-ААС 6 ДУГААР САРЫН 26-НЫ ӨДРИЙГ ДУУСТАЛ ҮРГЭЛЖИЛНЭ.**



Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал хурааж дуустал аливаа этгээд

СОНГОГЧДЫН САНАЛЫГ ТАТАХ зорилгоор дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг ХОРИГЛОНО!

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг



Мөнгө, эд зүйл тараах, бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэй үзүүлэх



Сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулах



Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах, нийтлэх



Тухайн жилийн төсөвт тусгаагүй нийгмийн халамж, хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх, амлалт өгөх, зарлах



Хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт өгөх



Нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, төлбөрт таавар, бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулах, ивээн тэтгэх



Ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулах, хэлцэл хийх



Сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амраах, сувилуулах

Сонгогчид бэлэн мөнгө, эд зүйл тараасныг сонгогч баримттайгаар цагдаагийн байгууллагад мэдэгдэж болно.

Сонгогчид хууль бусаар мөнгө, эд зүйл тараасан болох нь тогтоогдсон бол мэдээлэл гаргасан иргэн тараасан бэлэн мөнгө болон эд барааны үнийн дүнг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг гэм буруутай этгээдээс гаргуулахаар шаардах эрхтэй.

(Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 12 дугаар тогтоолоор батлаж, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын 2024 оны 6730 дугаарт бүртгэсэн)



УНШУУЛААРАЙ

РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААГ НЭВТРҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ, РАДИО, ТЕЛЕВИЗИЙГ БҮРТГЭХ, БҮРТГЭХЭЭС ТАТГАЛЗАХ ЖУРМЫН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлээр сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах талаарх зохицуулалт, баримтлах зарчмыг хуульчилсан байх бөгөөд хуулийн 46.20-д заасан энэхүү журмаар радио, телевизээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн сурталчилгаа хэрхэн нэвтрүүлэх, хяналт тавих, сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх радио, телевизийг хэрхэн бүртгэх, бүртгэхээс татгалзахтай холбогдсон харилцааг тодорхой болгосон.

Сонгуулийн сурталчилгааг Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-оос олгосон тусгай зөвшөөрөлтэй, сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхээр бүртгүүлсэн радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрөөр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх бөгөөд радио, телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуусталх хугацаанд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллах үүрэгтэй.

Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, радио, телевизийг бүртгэх, бүртгэхээс татгалзах харилцаанд хууль дээдлэх, ил тод, түргэн шуурхай байх, тэнцвэрт байдлыг хангах зарчмыг баримтлахаар журамд тусгасан бөгөөд Монгол Улсын Их хурлын ээлжит, ээлжит бус болон нөхөн сонгуулийн үеэр радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих харилцаанд энэ журмыг дагаж мөрдөхөөр зохицуулсан.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИАС...



46 дугаар зүйлийн 46.12-т "Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх радио, телевиз нь сонгуульд оролцогч бүх нам, эвсэл, нэр дэвшигчид тэгш хандах үүрэгтэй."



46.13-т "Радио, телевиз нь мэдээллийн хөтөлбөрөөрөө нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх сонгуулийн үйл явцын мэдээллийг хүргэхдээ бодит, тэнцвэртэй, нэг талыг барихгүй, хараат бус байх зарчмыг баримтална."



46.19-т "Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний ажилтан, албан тушаалтан сонгуулийн үйл ажиллагааны талаар бодит мэдээллийг түгээх үүрэгтэй.";



46.15-д "Радио, телевиз сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, хөтөлбөр бэлтгэж түгээх үүрэгтэй.";



46.27-д "Нам, эвсэл, нэр дэвшигчийн бэлтгэсэн сонгуулийн сурталчилгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байж болно.";



АБС

46.28-д "Радио, телевизийн хүүхдэд зориулсан нэвтрүүлэг дундуур сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно." гэж тус тус заасан нь радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа, сонгуулийн үйл явцын талаарх мэдээ мэдээлэл, сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл, нэвтрүүлэг, хөтөлбөр нэвтрүүлэхэд баримтлах гол үзэл санаа болно.

Радио, телевиз нэгээс илүү сувагтай бол сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийг аль нэг сувгаар нэвтрүүлэх ба сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх радио, телевизийн нэрийг сонгуулийн сурталчилгаа эхлэх өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө Харилцаа холбооны зохицуулах хороонд мэдэгдсэн байна. Харилцаа холбооны зохицуулах хорооноос сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх мэдэгдэл ирүүлэх боломжтой радио, телевизийн жагсаалтыг эзэмшлийн талаарх мэдээллийн хамт сонгуулийн сурталчилгаа эхлэх өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө гаргаж, өөрийн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх бол сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг холбогдох баримт бичиг, мэдээллийн хамт Харилцаа холбооны зохицуулах хороонд санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө ирүүлж бүртгүүлнэ. Бүртгүүлэх мэдэгдэлд **СУРТАЛЧИЛГААНЫ НЭВТРҮҮЛЭГ ЯВУУЛАХААР ТӨЛӨВЛӨСӨН ЦАГИЙН ХУВААРЬ, ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ЖИЛИЙН 01 ДҮГЭЭР САРЫН 01-НИЙ ӨДРӨӨС ӨМНӨХ ЖИЛИЙН 01 ДҮГЭЭР САРЫН 01-НИЙ ӨДРИЙГ ХҮРТЭЛХ ХУГАЦААНД БҮЮУ 2023.01.01-С 2024.01.01-НИЙ ХООРОНД ХИЙЖ БАЙСАН ГУРВААС ДООШГҮЙ ЗАР СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛЭХ ГЭРЭЭ**, тухайн гэрээ байгуулах үед мөрдөгдөж байсан үйлчилгээний үнэ тариф болон **сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх үнийн саналыг** хавсаргана.



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, СУУРЬ ОЙЛГОЛТ



ТӨРӨЛ:


- Радио, телевиз
- Олон нийтийн радио, телевиз
- Бусад радио, телевиз

БУСАД РАДИО, ТВ СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛЭХ БОЛ:

- ✓ **Бүртгүүлсэн байх - эрх бүхий радио, телевиз**
- ✓ Бүртгүүлээгүй -эрхгүй радио, телевиз

ХХЗХ-НД БҮРТГҮҮЛСЭН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛЭХ ЭРХ БҮХИЙ РАДИО ТЕЛЕВИЗ

- **Сонгуулийн сурталчилгаа**- хоногт 60 минут (нэг нам, эвсэлд, түүнчлэн бие даан нэр дэвшигчдэд 25 хувиас илүүгүй байх)
- **Мэдээ** - нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ хоногт 5 минут
- **Мэтгэлцээн** - нэг намын бус, хэд хэдэн нэр дэвшигч, өөр өөр нам, эвсэлийн төлөөлөл, оролцогчдын тоо
- **Сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, хөтөлбөр**



46.28. Радио, телевизийн хүүхдэд зориулсан нэвтрүүлэг дундуур **СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОНО** -хууль



АБС

46.9. ХҮҮХЭД, ТЕЛЕ-ХУДАЛДААНЫ ТӨРӨЛЖСӨН болон төлбөртэй радио, телевизээр **СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛЭХГҮЙ** -журам



АБС



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛЭХ РАДИО, ТЕЛЕВИЗИЙН БҮРТГЭЛ

Сонгуулийн сурталчилгаа хийх хугацаа

2024.06.10-2024.06.26

1

Радио телевиз нэгээс илүү сувагтай бол сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх радио, телевизийн нэрийг... (сонгуулийн сурталчилгаа эхлэх өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө) ХХЗХ-нд мэдэгдэх

2024.04.25-аас өмнө

2

ХХЗХ: мэдэгдэл ирүүлэх боломжтой радио, телевидийн ЖАГСААЛТ, эзэмшлийн мэдээллийг сонгуулийн сурталчилгаа эхлэх өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө гаргах

2024.04.25-ны дотор

Мэдэгдэл ирүүлэх боломжтой радио, телевизийн жагсаалт, эзэмшлийн мэдээлэл-ийг гаргаж src.gov.mn цахим хуудсаар мэдээлнэ.

3

Радио, телевиз жагсаалтад орсон бөгөөд сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх бол... сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай МЭДЭГДЛИЙГ (санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө) ХХЗХ-нд ирүүлнэ.

2024.04.28-ны дотор
(5.01-5.28)

Мэдэгдлийн маягт-ыг src.gov.mn цахим хуудсаар мэдээлнэ.
МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн 46.9-д заасан БАРИМТ, МЭДЭЭЛЭЛ-ийг хавсаргаж ирүүлнэ.

ХХЗХ:

1. Радио телевизээс ирүүлсэн мэдэгдлийг ХЯНАЖ
2. Бүртгэх эсэх
3. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхээр бүртгүүлсэн, эрх бүхий радио, телевизийн ЖАГСААЛТ БАТЛАХ

2024.05.28

Жагсаалтыг нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд хүргүүлнэ.
Өдөр тутмын сонинд нийтлүүлнэ
Жагсаалтыг src.gov.mn цахим хуудсанд байршуулан нийтэд ил тод мэдээлнэ

Бүртгүүлсэн радио, телевиз сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй. **БҮРТГҮҮЛЭЭГҮЙ РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ НЭВТРҮҮЛЭГ НЭВТРҮҮЛЭХИЙГ ХУУЛИАР ХОРИГЛОСОН.**

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛЭХ ЭРХ



Бүртгүүлсэн



Бүртгүүлээгүй

Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсоно.



Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх

2024 оны
6.10-6.26



Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхгүй:

2024 оны
6.27-28



Санал авах өдөр:

2024 оны
6.28



нам, эвсэл, нэр дэвшигчид хамаарах захиалагч, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг дурдаагүй төлбөрт, захиалгат нэвтрүүлэг, зар сурталчилгаа нэвтрүүлсэн бол;



захиалагч, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой бичээгүй, дурдаагүй аливаа нэвтрүүлэгт улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн таних тэмдэг, уриа, намын далбаа, зураг, дүрс, нэрийг үзэгч, сонгогчдод сонгуулийн сурталчилгаа гэж ойлгогдохуйц байдлаар харуулах, дурдах, байршуулах, дууны үгэнд дурдсан бол;



сонгуулийн сурталчилгааны бус нэвтрүүлэг, арилжааны сурталчилгаа зэрэгт нам, эвсэл, нэр дэвшигчийн таних тэмдэг, уриа, намын далбаа, зураг, дүрсний бичлэг, яриа нь орсон бол.

Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт нэг цаг **/60 минут/-**аас илүүгүй байх ба сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хоногт гарах нийт хугацаа /60 минут/-ны хорин таваас илүүгүй хувь **/15 минут/** нь нэг нам, эвсэлд, түүнчлэн бие даан нэр дэвшигчдэд ногдоно.

Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт **таван минутаас** хэтрүүлэхийг хориглох бөгөөд нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар гарсан мэдээ нь сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хугацаанд хамаарахгүй. Радио, телевиз нь өөрийн редакцияд баримтлах бодлого, зохицуулалтын хүрээнд мэдээний таван минутын хэрэгжилтэд хяналт, мониторинг хийж, хэрэгжилтийг хангуулж ажиллана.

СОНГУУЛИЙН
СУРТАЛЧИЛГААНЫ
НЭВТРҮҮЛЭГ
60 МИНУТ /ХОНОГТ/



МЭДЭЭ
5 МИНУТ /ХОНОГТ/



Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6, 46.7-д заасан сонгуулийн сурталчилгаа, 46.14-т заасан мэдээний хоногт гарах нийт хугацаанд тухайн нэвтрүүлэг, мэдээний давталт хамаарна.

Сонгуулийн талаарх дараах нэвтрүүлэг, сурталчилгаа нь сонгуулийн сурталчилгаанд хамаарахгүй. Үүнд:

- сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар болон сонгуулийн үйл явцын тухай радио, телевизийн өөрийн редакцын бэлтгэсэн мэдээ, сурвалжилга, тойм;
- сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг, сурталчилгаа;
- улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг;
- бүх шатны сонгуулийн байгууллагын албан ёсны мэдээ.



Радио, телевиз нь сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн үйл явцын мэдээлэл, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг, сурталчилгаа, бүх шатны сонгуулийн байгууллагын албан ёсны мэдээнээс бусад сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, сурвалжилга, тойм, эсхүл сонгуульд оролцогч нам, эвслийн дарга, нэр дэвшигч оролцсон аливаа нэвтрүүлэг, мэтгэлцээн, хөтөлбөр, дуу, ярилцлагыг нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авна.

Улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг, хөтөлбөр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамаарахгүй боловч уг нэвтрүүлэг, хөтөлбөрт нэг намын бус, түүнчлэн бие даагч хэд хэдэн нэр дэвшигч, эсхүл өөр өөр нам, эвслийн төлөөлөл оролцсон байх ба улс төрийн мэтгэлцээний нэвтрүүлэг, хөтөлбөр нэвтрүүлэхдээ оролцогчдод ижил асуулт тавих, хариултын тэнцүү хугацаа тогтоох зэрэг мэтгэлцээний тогтсон дэгтэй байх ба оролцогчийн нэрийг, нам, эвслийн төлөөлөл, нэр дэвшигч бол нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэрийн хамт тодорхой илэрхийлнэ.

Телевиз нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг, мэдээ мэдээлэл болон улс төрийн мэтгэлцээн бэлтгэн хүргэхдээ хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай байна.

**Харилцаа холбооны зохицуулах хорооны
Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газар**

ЦАХИМ ОРЧИН АШИГЛАН
СУРТАЛЧИЛГАА ЯВУУЛАХ,
ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ
ЖУРМЫН ЗОХИЦУУЛАЛТ

Сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудсыг бүртгүүлэх.

Цахим хуудас	Тайлбар	Бүртгэл	Хугацаа
47.1.1 нэр дэвшигчийн болон нам, эвслийн өөрийн тус бүр нэг цахим хуудас	Нэр дэвшигчийн, нам эвслийн вэбсайт	Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо	2024.06.10-аас эхлэн 2024.06.12-ыг дуустал
47.1.2 цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудас;	Нам эвсэл, нэр дэвшигчийн олон нийтийн сүлжээний цахим хуудаснууд /пэйж хуудас, профайл/	Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо	2024.06.10-аас эхлэн 2024.06.12-ыг дуустал
47.1.3 бусад цахим хуудас	Бусад вэбсайт	Харилцаа холбооны зохицуулах хороо	2024.06.10-аас өмнө

Нам, эвсэл, нэр дэвшигч болон үйлчилгээ эрхлэгчдийн чиг үүрэг

Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч болон интернэтийн үйлчилгээ эрхлэгч	Цахим орчны үйлчилгээ эрхлэгч	Нам, эвсэл, нэр дэвшигч
5.1.5.зөрчилтэй домэйн нэрийн жагсаалтыг сонгуулийн сурталчилгаа эхэлснээс сонгуулийн санал авах өдрийн дараах өдөр хүртэл хугацаанд 4 цаг тутамд шинэчлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд нэн даруй шинэчлэх;	5.2.1.сонгуулийн сурталчилгааг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль тогтоомжид заасны дагуу явуулах; 5.2.2.энэ журмын 6.3-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, гүйцэтгэх техник, технологийн боломжийг хангасан байх; 5.2.3.нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгааг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс сонгуулийн санал авах өдрийн дараах өдөр хүртэл хугацаанд түр хязгаарлах буюу сонгогчдод харагдахгүй болгох технологийн арга хэмжээ авах;	5.3.2. нам, эвсэл, нэр дэвшигч нь цахим хуудас болон цахим шуудангийн мэдээллээ аливаа халдлагаас урьдчилан сэргийлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
5.1.10. интернэтийн үйлчилгээ эрхлэгч нь хэрэглэгчийн нэг удаагийн холболт дахь бүх хандалт нэг гадаад АйПи (IP) хаягаар дамжих боломжийг бүрдүүлэх бөгөөд харгалзах /гадаад, дотоод/ хаягуудын мэдээллийг 1 сарын хугацаанд хадгална.	5.2.4.сонгуулийн сурталчилгаа хийсэн тохиолдолд сонгуулийн сурталчилгааг захиалсан этгээд болон сонгуулийн сурталчилгааны төлбөрийн талаарх мэдээлэл агуулсан тайланг сонгуулийн санал хураах өдрийн дараа өдрөөс хойш 30 хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан Сонгуулийн сурталчилгаа явуулсан тайлангийн загварын дагуу бэлтгэж, Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх; 5.2.5. домэйн нэр ашиглан мэдээ мэдээллийг хэрэглэгчид хүргэж буй бүх төрлийн вэб сайт нь сонгуулийн сурталчилгаа явуулахдаа сэтгэгдэл бичигдэхгүй тохиргоотойгоор нийтлэх; 5.2.6. Харилцаа холбооны зохицуулах хорооноос шаардсан мэдээллийг тухай бүр гаргаж хүргүүлэх.	5.3.3. нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаанд ашигласан цахим хуудсыг сонгуулийн сурталчилгаа дууссан өдрөөс сонгуулийн санал авах өдрийн дараах өдөр хүртэл хугацаанд түр хязгаарлах буюу сонгогчдод харагдахгүй болгох технологийн арга хэмжээ авах.

(Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 3 дугаар сарын 6-ны 14 дүгээр тогтоолоор батлаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2024 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 6748 дугаарт бүртгэсэн)




УНШУУЛАРАЙ

Зураг 1. Сонгуулийн зардал, сурталчилгаа, бүртгэл



СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ЗУРАГТ САМБАР

Зардал бууруулах, олон улсын жишигт нийцүүлэх онцлох шийдэл нь сонгуулийн сурталчилгааны ЗУРАГТ САМБАР юм.



НЭГДСЭН САМБАР

Тойрогт нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулсан НЭГДСЭН САМБАР-ыг суманд 2, аймгийн төвийн суманд 5, хороонд 4-ийг бэлтгэж, байрлуулах ажлыг сум, дүүргийн Засаг дарга хариуцна. Нэр дэвшигчдийн зурагт хуудсыг саналын хуудаст нэр дэвшигчийн нэрийг бичих дарааллын дагуу байрлуулахаар зохион байгуулах юм. Нэгдсэн самбарт байрлах нэр дэвшигчийн зурагт хуудас нь 1 хэвлэлийн хуудасны дөрөвний нэг буюу АЗ хэмжээтэй байна.

Нэгдсэн самбарыг байршуулах цэгийг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож, нийтэд мэдээлнэ.

Нэгдсэн самбар байрлуулснаар сонгогч нэг дороос бүх нэр дэвшигчийн мэдээллийг авах боломжтой.

ЗУРАГТ САМБАР

Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нийтийн эзэмшлийн газар буюу гудамж, талбайд сурталчилгааны хугацаанд 8 хэвлэлийн хуудаснаас илүүгүй хэмжээтэй ЗУРАГТ САМБАР-ыг суманд 1, хороонд 2 хүртэл үнэ төлбөргүй байрлуулж болно. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зурагт самбар байрлуулах гудамж, талбайг тогтоож, нийтэд мэдээлэх юм.

Нэгдсэн самбар болон зурагт самбар байрлуулахдаа замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгслийг халхлах, бусдын эд хөрөнгө, явган зорчигчдод аюул учруулж болзошгүй байдлаар байрлуулах, замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглосон.



ХОРИГЛОХ




Бизнесийн зорилгоор байнга ашиглагддаг сурталчилгааны самбар, дэлгэц, түүний орон зайг сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй.



Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, нэр дэвшигчийн ухуулах байр байрлаж байгаагаас бусад байшин, барилга байгууламжид сонгуулийн сурталчилгааны самбар байрлуулахгүй.



Нэгдсэн самбар болон зурагт самбар байрлуулахдаа замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгслийг халхлах, бусдын эд хөрөнгө, явган зорчигчдод аюул учруулж болзошгүй байдлаар байрлуулах, замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.



Б.БУНДХОРОЛ:

МӨРИЙН ХӨТӨЛБӨР НЬ ХЭРЭГЖИХ ЭРХ ЗҮЙН БОЛООД САНХҮҮГИЙН БОЛОМЖТОЙ, БОДЛОГЫН ЦОГЦ ШИЙДЭЛ БАЙХ ЁСТОЙ

Нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайланд дүгнэлт гаргах үйл ажиллагааны талаар Үндэсний Аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, Тэргүүлэх аудитор Б.Бундхоролтой ярилцлаа.

-Төрийн аудитын байгууллага сонгуулийн хууль тогтоомжийн хүрээнд ямар, ямар аудит хийдэг вэ?

-Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд зааснаар Төрийн аудитын байгууллага дүгнэлт гаргах, аудит хийх хэд, хэдэн үе шат бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг хүлээдэг. Тодруулбал,

- УИХ-ын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох;

- УИХ-ын ээлжит сонгуульд оролцохоо илэрхийлсэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргах;
- УИХ-ын ээлжит сонгуулийн жилийн өмнөх нэг жилийн хугацаанд тухайн сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан

баталгаажуулах;

- УИХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, үр дүнг олон нийтэд мэдээлэх;
- Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс зарцуулсан зардлын гүйцэтгэлд, түүнчлэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах гэсэн ажлуудыг сонгуулийн жилдээ гүйцэтгэхээр хуульчилсан.

-Өмнөх сонгуулиудын мөрийн хөтөлбөрийн заримыг хэрэгжих боломжгүй, мөрөөдлийн жагсаалт гэх шүүмжлэл гарсан. Мөрийн хөтөлбөрт аудит хийхдээ ямар үзүүлэлтүүдийг чухалчилдаг вэ?

-Сонгуулийн мөрийн хөтөлбөр бол иргэдийн сонголт хийхэд нөлөөлдөг гол хүчин зүйлсийн нэг. Сонгуульд ялсан нам, эвслийн мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын Засгийн газрын ирэх дөрвөн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн үндэс болдог. Тиймээс нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн дэвшүүлж буй сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогод нийцсэн эсэх, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар Төрийн аудитын байгууллага хянаж дүгнэлт гаргахаар хуульчилсан.

-Хөгжлийн бодлоготой нийцсэн, төсвийн хувьд хэрэгжүүлж болохуйц эсэхийг хянах юм байна, тийм үү?

-Товчхондоо, сонгуульд оролцохоо илэрхийлж мөрийн хөтөлбөртөө тусгасан зорилт, арга хэмжээ нь хий хоосон амлалт бус, улсын хэмжээнд мөрдөж буй хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжих эрх зүйн болоод санхүүгийн боломжтой буюу хуульд заасан шаардлагын дагуу хэрэгжих үндэслэл бүхий түүнийгээ хэрхэн хэрэгжүүлэх тухай дэвшүүлсэн бодитой, бодлогын цогц шийдэл байх ёстой. Сонгуульд оролцож байгаа этгээд нь үзэл баримтлал, чиг баримжаагаа тайлбарлаж байгаа хэдий ч мөрийн хөтөлбөртөө тусгасан зорилт, арга хэмжээ нь бодлогын өрсөлдөөн гэдэг агуулгаараа чухал баримт бичиг юм.

Төрийн аудитын байгууллагын хувьд хууль дээдлэх зарчим, төрийн аудитын хараат бус, ил тод, хариуцлагатай байдлын түгээмэл зарчмын хүрээнд аудит хийх, дүгнэлт гаргах үйл ажиллагаандаа стандарт, дүрэм журмаа баримтлан нам, эвсэл, нэр дэвшигчдээс ирүүлж байгаа мөрийн хөтөлбөрт бодитой дүгнэлт гаргахыг хичээн ажилладаг.

-Ер нь мөрийн хөтөлбөрүүдэд нийтлэг гардаг зөрчил юу вэ?

-Сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигч дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих сонгуулийн мөрийн хөтөлбөртөө амлалт хэлбэрээр тусгахыг хориглосон зүйлсийг хуульд тодорхойлсон байдаг.

Дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээнд мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгөтэй холбоотой эрх олгох, иргэдэд үнэ төлбөргүй, эсхүл хямдралтай үнээр үйлчилгээ үзүүлэх, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийг иргэдэд тараан олгох, шууд зарцуулахтай холбогдсон асуудал зэрэг хуулиар хориглосон зүйлсийг зарим тохиолдолд тусгаж ирүүлж байсан өмнөх практикийг хэлэх нь зүйтэй байх.

Түүнчлэн санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн буюу санхүүжилтийн эх үүсвэр, зардлын тооцоог ирүүлэхгүй байх явдал гарч байсан.

-Мөрийн хөтөлбөрөө засаж залруулах боломжийг олгодог уу?

-Хуульд зааснаар нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлага хангаагүй гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулахаар Төрийн аудитын байгууллагад ирүүлэхээр зохицуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, сонгуулийн мөрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлагад нийцээгүй тохиолдолд нэг удаа засах боломжийг олгож байгааг хэлж байгаа хэрэг.

Сонгуулийн мөрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлага хангасан тухай Төрийн аудитын байгууллагын дүгнэлт гарснаар сонгуульд оролцох эрх үүснэ. Манай байгууллага нам, эвслийн мөрийн хөтөлбөрт хийсэн дүгнэлтийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө, бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт хийсэн дүгнэлтийг

“

**СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР
НЬ ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГА
ХАНГАСАН ТУХАЙ ТӨРИЙН
АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН
ДҮГНЭЛТ ГАРСНААР СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ ЭРХ ҮҮСНЭ.**

УИХ-ЫН
МОНГОЛ
УЛСЫН
ХӨГЖЛИЙН
БӨЛӨГ

санал авах өдрөөс 33-аас доошгүй хоногийн өмнө гаргаж Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлдэг.

-Нам, эвсэл, нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоосон. Сонгуулийн зардлын дийлэнхийг хандиваар олдог. Хандивын тайланд ямар шалгуураар дүгнэлт гаргадаг вэ?

-2023 онд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж байна. Эдгээр хуулиудад сонгуулийн хандивтай холбоотой зохицуулалтууд бий.

Хандивын тайлан нь ээлжит сонгуулийн жилийн гуравдугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн нэгдүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааг хамруулах шаардлагатай байдаг.

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн хандивын тайланг хянан баталгаажуулж дүгнэлт гаргадаг. Хандивын дэлгэрэнгүй жагсаалтыг холбогдох төрийн байгууллага, арилжааны банкнуудаас гаргуулан авсан лавлагаа, мэдээлэл, судалгаатай тулган хянан баталгаажуулж дүгнэлтийг гаргана. Хандивын тайланд тусгаагүй аливаа хандивыг хянан баталгаажуулахгүй.

Аудитыг хийхдээ хуульд заасан хориглолт хязгаарлалтыг хамруулан үздэг. Тухайлбал, мөнгөн хандив нь иргэний хувьд арван сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд гучин сая төгрөг хүртэл байж болно. Мөн гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, 18 нас хүрээгүй хүн, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан татварын өр төлбөртэй, дампуурсан хуулийн этгээд зэрэг хандив өгөхийг хориглосон этгээд сонгуулийн хандив өгсөн бол хандив хүлээн авах эрх бүхий этгээд буцаан шилжүүлэх үүрэгтэй байдаг. Энэ үүргээ зөрчиж хүлээн авсан хандивыг улсын орлогод оруулах буюу төрийн санд шилжүүлэх хуулийн зохицуулалттай.

-Сонгууль дууссаны дараа хэдий хэмжээний зардлыг юунд зарцуулснаа бас тайлагнах ёстой юу. Энэ тайлангийн үр дагавар нам, эвсэл, нэр дэвшигчдэд хэрхэн нөлөөлөх вэ. Өөрөөр хэлбэл, тайлангаа өгөөгүй,

буруу мэдээлсэн бол УИХ-ын гишүүнээс эгүүлэн татах, дараагийн сонгуульд нэр дэвших эрхийг хасах ч юм уу хариуцлага бий юү?

-Сонгуульд оролцоно гэдэг бол нэг талаасаа сонгогдох эрхээ эдэлж байгаа боловч нөгөө талаасаа сонгох эрхээ эдэлж буй сонгогчдынхоо өмнө маш чухал үүрэг, хариуцлага хүлээж байгаа юм. Ийм ч учраас сонгуульд оролцож байгаа л бол тухайн нам, эвсэл болон нэр дэвшигч нар ямар зардлаар, ямар хандиваар сонгуульд оролцож байгаа нь буюу санхүүжилт нь ил тод байх, тэрхүү санхүүжилтийн тайлангаа хариуцлагатайгаар сонгогчдоо тайлагнах үүрэгтэй байхыг хуулиар нарийн зохицуулсан. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сонгогчдод сурталчлах, тайлбарлан таниулах зорилгоор сонгуулийн сурталчилгааны шууд болон шууд бус зардал гаргадаг. Сонгуулийн зардлын хувьд хандив, намын хөрөнгө, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгөөс бүрдэнэ. Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийг хуульд заасны дагуу нээлгэсэн сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлж, зарцуулах шаардлагатай ба өөр дансанд сонгуулийн зардал цуглуулах нь хуулиар хориотой.

Тийм учраас Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

Харин нэр дэвшигч, нам, эвсэл авсан хандив болон сонгуулийн зардлын зарцуулалтын явцын тайланг санал авах өдрөөс гурав хоногийн өмнө нийтэд ил тод мэдээлж, Төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлэх үүрэг хүлээсэн байдаг.

Хариуцлагын хувьд нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эрх зүйн зохицуулалт Зөрчлийн тухай хуульд бий.

-Ярилцсанд баярлалаа.

УИХ-ЫН
СУДАЛГААНЫ САН



С.ОЮУНТУЯА: МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛ “СОНГОГЧТОЙ БАЙГУУЛЖ БУЙ ГЭРЭЭ” ЮМ

“Сонгогчдын Боловсрол Төв”-ийн гүйцэтгэх захирал С.Оюунтуяатай ярилцлаа.

-Сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл Үндэсний аудитын газарт мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар хүргүүлсэн. Сонгогчдод мөрийн хөтөлбөр яагаад чухал болох талаар яриагаа эхэлье.

-Сонгуулийн мөрийн хөтөлбөр бол улс төрийн нам, эвслийн хувьд сонгуулийн сурталчилгааны үндсэн баримт бичиг болдог бол сонгогчдын хувьд саналаа өгөх гол эх үүсвэр болдог. Товчхондоо бол тухайн ээлжит сонгуулийн хугацаанд юуг, яаж хийх талаар багтаасан бодлогын баримт бичиг юм. Тиймээс нам, эвсэл, нэр дэвшигчид мөрийн хөтөлбөрөө боловсруулахдаа улс орны хувьд болон тухайн орон нутаг, хүмүүст тулгамдаж буй асуудлыг сайн судалж, мөн тэднээс сайтар асууж байж боловсруулах ёстой. Зөвхөн тухайн сонгуулиар сонгогчдын саналыг авахад чиглэсэн

гоё сайхан амлалт, мөрөөдлийн жагсаалт биш харин хуульд заасан тодорхой шаардлага хангасан, урт хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн, тулгамдсан асуудлаа, шийдэл, хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй нь багтаасан байх ёстой юм л даа.

-Тэгэхээр сонгуулийн мөрийн хөтөлбөр нь зүгээр ч нэг амлалт биш, харин тулгамдсан асуудлын шийдэл, төлөвлөгөө байх нь ээ.

-Тэгэлгүй яах вэ. Улс төрийн намууд мөрийн хөтөлбөрөө өөрийн намын үзэл баримтлалдаа нийцүүлэн, сонгогчдын хүлээлт, эрэлт хэрэгцээнд үндэслэн, тэдэнд тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэх хувилбартай нь хамт санал болгодог. Энэ удаагийн сонгуулийг холимог системээр

зохион байгуулна. Өөрөөр хэлбэл, сонгогч тойрогт нэр дэвшиж буй нэр дэвшигчдэд санал өгөхөөс гадна улс төрийн намын жагсаалтаас сонгож саналаа өгнө. Тэгэхээр намууд хөгжлийн бодлогын баримт бичиг болох мөрийн хөтөлбөрөө өрсөлдүүлж, сонгуульд оролцох нь. Сонгуулийн үр дүнд ялсан улс төрийн намын мөрийн хөтөлбөр нь тухайн сонгуулийн үр дүнд байгуулагдах Засгийн газрын үйл ажиллагааны үндэс болдог утгаараа "сонгогчтой байгуулж байгаа гэрээ" юм. Тиймээс сонгогч "сонгуульд саналаа өгнө" гэдэг нь зөвхөн санал авах өдөр санал авах байранд очиж, саналын хуудас тэмдэглэх төдий биш харин мөрийн хөтөлбөрт онцгой ач холбогдол өгч, судалж, уншиж, харьцуулахаас эхэлнэ.

-Ажиглаад байхад сонгогчид сонгуульд оролцож байгаа нам, эвслийн мөрийн хөтөлбөрийг сайн судалдаггүй санагддаг. Энэ талаар таны бодол.

-Сонгогчдын зан төлөвийг ажиглахад мөрийн хөтөлбөрийг судалдаг, харьцуулж шинжилдэг нь бага л санагддаг. Гэхдээ Улсын Их Хурлын 2020 оны сонгуулийн үед ирж байсан лавлах утасны дуудлагад нам, эвслийн мөрийн хөтөлбөрийг хаанаас олж үзэх вэ, мөрийн хөтөлбөрт харьцуулсан судалгаа хийсэн болов уу гэх зэргээр сонгогчид сонирхож асуух нь нэмэгдсэн. Тэгэхээр сонгогчид бас ч гэж сонгуулийг мөрийн хөтөлбөрийн буюу бодлогын өрсөлдөөн гэж ойлгож эхэлж байгаа нь сайн хэрэг. Нөгөө талаас сонгуульд оролцож буй нам, эвсэл нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг нэг дороос, цэгцтэй байдлаар сонгогч үзэх, танилцах боломжийг бүрдүүлэх нь чухал юм.

-Та сая "сонгууль бол бодлогын өрсөлдөөн" гэж хэллээ. Үүнийгээ жаахан тодруулах уу.

-Энэ удаагийн парламентын сонгууль нэг талаараа их онцгой сонгууль болох гэж байна шүү дээ. Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр улс төрийн намыг "бодлогын нам" болгох, үүнд нийцүүлэн Улс төрийн намын хуулийг шинэчилж, намын дотоод ардчилал, санхүүжилтийн асуудлыг цоо шинээр авч үзлээ. Тэгэхээр улс төрийн намууд ч гэсэн сонгогчдыг элдэв амлалтаар хуурах биш харин жинхэнээсээ улс орны хөгжлийн "бодлого"-оор өрсөлдөх боломжийг хуульчилсан. Тиймээс нэг талаасаа сонгогчид ч гэсэн улс төрийн намаас ийм шинэчлэлийг хүлээж байгаа байх гэж бодож байна.

-Сонгууль бүрийн өмнө үнэн, худал нь мэдэгдэхгүй маш их мэдээлэл түгдэг. Сонгогч мөрийн хөтөлбөртэй холбоотой, ер нь сонгуультай холбоотой бодит мэдээллийг хаанаас олж авах вэ?

-Хэзээ сонгогчийн оролцоо бодитой байх вэ гэхээр сонгууль болон сонгуулийн үйл явц, сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар хангалттай мэдээлэлтэй байх үед. Сонгуулийн хууль тогтоомжоор сонгуулийн кампанит ажлын хугацаа маш богино, дээр нь энэ удаагийн сонгуульд тойргийг томсгож, бүс нутгаар нь хуваасан. Ийм богино хугацаанд ялангуяа сонгуульд оролцож байгаа нам,

эвсэл, нэр дэвшигч бүрийн мөрийн хөтөлбөртэй сонгогч нэг бүрчлэн танилцаж, саналаа өгнө гэж үзэхэд маш төвөгтэй. Дээр нь сонгуулиар маш олон эх үүсвэрээс их хэмжээний мэдээлэл түгдэг тул хуурамч, худал мэдээллээс үнэн зөв мэдээллийг ялгахад бас хэцүү. Уг нь бусад улс орнуудад энэ тохиолдолд сонгогчдод сонгуульд оролцож буй этгээдүүдийн мөрийн хөтөлбөрийг нэг эх сурвалжаас хүргэх, түүнд харьцуулсан судалгаа, шинжилгээ хийж, сонгогчдыг мэдээллээр хангах ажлыг сонгуулийн байгууллагаас эхлээд төрийн бус байгууллагууд хүртэл хийдэг. Бидэнд одоогоор ийм тогтолцоо бараг байхгүй шүү дээ. Ямартаа ч анх удаа нэр дэвшигчдийн нэгдсэн самбарыг төрөөс зохион байгуулж, сонгогчдод ойртуулж, мэдээлэл хүргэхээр болсон нь сайн хэрэг. Үүнтэй адилаар сонгуулийн байгууллага, мөрийн хөтөлбөрийн гол гол зорилтуудыг тухайлбал, эдийн засаг, нийгэм, эрүүл мэнд, боловсрол, татварын зэрэг асуудлаар харьцуулсан мэдээллийг бэлтгэн сонгогчдод хүргэвэл сонгогчдын боловсролд маш том хувь нэмэр болж, сонгогчид ч мэдээлэлтэйгээр сонголтоо хийхэд дөхөм болох юм. Харин энэ мэдээллийг бэлтгэхдээ аль нэг талыг барихгүй байх нь чухал.

-Сонгуулийн байгууллагаас өөр мэдээлэл авч болох эх сурвалжуудыг тодруулбал?

-Байлгүй яах вэ, хамгийн түрүүнд Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудсыг дагаж тогтмол мэдээлэл авч байх нь чухал. Мөн сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн албан ёсны цахим хуудас, тэдний зохион байгуулдаг уулзалт, арга хэмжээ, ухуулах байранд очиж мөрийн хөтөлбөрийн талаар мэдээлэл авах боломжтой. Түүнчлэн сонгогчид сонгох эрхээ хэрэгжүүлэхэд зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг манайх шиг төрийн бус байгууллагууд ч бий. Сонгогчдын Боловсрол Төвийн хувьд ээлжит сонгууль тус бүрээр сонгогчийн лавлах утсыг ажиллуулдаг. **1800-2800** сонгогчийн лавлах утсанд хандаж сонгуулийн талаар мэдээлэл авах боломжтой шүү. Хэвлэл мэдээллийн байгууллагууд хүртэл сонгогчдод зориулсан сонгуулийн боловсролын мэдээлэл бэлтгэж, түгээх үүргийг хуулиар хүлээсэн байдаг.

-Сонгуулийн мөрийн хөтөлбөртэй холбоотой сонгогчдод юу захиж хэлэх вэ.

-Бид анх удаа бүсчилсэн том тойргоор сонгуулиа зохион байгуулах гэж байна. Дахин дахин хэлэхэд тойргийн газар нутаг томрохын хэрээр нам, эвсэл, нэр дэвшигч бүр сонгогчтой нэг бүрчлэн уулзах боломжгүй гэсэн үг. Тиймээс сонгогч өөрөө эрэл хайгуул хийж, мөрийн хөтөлбөрийг хайж, судалж, танилцаж хариуцлагатай байхаас өөр аргагүй. Яагаад гэвэл, дараагийн дөрвөн жил ямар нам, эвсэл, хүмүүсээр удирдуулахаа, ямар бодлого, мөрийн хөтөлбөрийн үр шимийг хүртэж амьдрахаа шийдэх эгзэгтэй үе бол зургаадугаар сарын 28-ны өдөр буюу сонгуулийн санал авах өдөр юм. Санал авах байр руу явахаас өмнө мөрийн хөтөлбөрүүдийг нь дахин нэг санаарай гэж хэлье дээ.

Н.НАРАНЦЭЦЭГ:

СОНГОГЧ СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТАД БҮРТГЭГДСЭН ЭСЭХЭЭ ШАЛГАХ ҮҮРЭГТЭЙ

Сонгогчдын нэрийн жагсаалтын талаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын ахлах мэргэжилтэн Н.Наранцэцэгтэй ярилцлаа.

-Сонгогчдын нэрийн жагсаалт WWW.ELECTION.BURTSEL.GOV.MN цахим санд байршсан. Иргэний ямар мэдээллүүд байгаа вэ?

-Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэгт "Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа сонгуулийн эрх бүхий иргэний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн мэдээллийг аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороогоор болон хэсэг нэг бүрээр нэгтгэн гаргах бөгөөд уг жагсаалтыг ээлжит сонгуулийн жилийн 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, сонгууль дуустал өөрийн цахим хуудсанд байршуулна" гэж заасан шүү дээ. Сонгогч улсын бүртгэлийн байгууллагын burtgel.gov.mn цахим хаягт нэвтэрч <http://election.burtgel.gov.mn> холбоосоор регистрийн дугаараа бичээд нэвтэрвэл эцэг /эх/ болон өөрийн нэр, хаяг болон сонгуулийн тойргийн дугаар, хэсэг, санал өгөх байрны хаягийн мэдээлэл байгаа.

"Сонгогчдын нэрийн жагсаалтын маягт загвар"-ыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан "Журам, загвар, маягт батлах тухай" 2024 оны А/11, А/22 дугаар тушаалын хавсралтаар баталсан.

-Өөрийнхөө мэдээллийг шалгахад хаяг дээр байгаа бусад хүний мэдээлэл гарах уу?

-Өөрийнх нь мэдээллээс гадна тухайн хаягт байгаа



нийт сонгогчдын мэдээлэлтэй танилцах боломжтой. Хаягт бүртгэлтэй сонгогчийн тоог заагаад, харах цэс дээр дарвал нэрс нь гарна гэсэн үг.

-“Манай хаяг дээр танихгүй хүмүүс байна”, “намайг өөр хаяг дээр бүртгэсэн байсан” гэх яриа гардаг. Мэдээлэл алдаатай байвал яаж засуулах вэ?

-Сонгогч мэдээлэлтэй танилцах явцад зөрүүтэй, буруу бүртгэгдсэн, эсхүл оршин суух хаягт нь үл таних иргэн бүртгэгдсэн зэрэг асуудлаар өөрийн харьяа улсын бүртгэлийн байгууллагын холбогдох нэгжид өргөдөл, хүсэлтээ гаргаж шийдвэрлүүлэх бүрэн боломжтой.

Иргэний мэдээлэл зөрүүтэй бол тухайн мэдээллийн хэсгийн арын тэмдэглэгээг идэвхжүүлнэ. Өөрөөр хэлбэл, зөрүүтэй мэдээллийг идэвхжүүлээд утасны дугаар, и-мэйл хаяг, нэмэлт тайлбар бичих цонхонд мэдээллээ бичиж илгээнэ. Улмаар таны өргөдөл хүсэлтийг “аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст шилжүүллээ” гэсэн мэдээлэл гарах юм. Аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс зөрүүтэй иргэний мэдээллийг шалгаж, өргөдөл, хүсэлт гаргасан этгээдэд шийдвэрлэлтийн талаар мэдэгдэж ажиллана.

Тухайн сонгогчийн мэдээлэл ямар ч зөрүүгүй байхад алдаатай гэсэн мэдээлэл илгээх асуудал цөөнгүй гардаг. Энэ нь улсын бүртгэлийн хэлтсийн ачааллыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх тул зөвхөн зөрүүтэй тохиолдолд л мэдээлээрэй гэж хүсье.

-Зөрүүтэй мэдээллийг засуулах хүсэлтийг хэдий

хугацаанд шийдвэрлэх вэ?

-Иргэний өргөдөл хүсэлтийг шуурхай шийдвэрлэх боломжтой бол тухай бүр шийдвэрлээд явна. Харин судлан үзэх шаардлагатай зарим тохиолдолд /иргэний хаягийг түдгэлзүүлэх/ эрх бүхий этгээд Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу эрх, үүргийг хэрэгжүүлэн ажиллах тул хугацаа шаардлагатай нь ойлгомжтой юм.

-Сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим санд хэдий хүртэл байрших вэ. Иргэд хэдийд мэдээллээ шалгах боломжтой бол?

-Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд "Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шалгасан байвал зохино" гэсэн сонгогчийг үүрэгжүүлсэн зохицуулалт байгаа.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг хуульд заасны дагуу ээлжит сонгуулийн жилийн 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сонгуулийн санал хураалт явагдаж дуустал байршуулна. Энэ хугацаанд иргэн өөрийн мэдээллийг шалгахын зэрэгцээ сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн мэдээлэлтэй танилцаж болно.

-Бүртгэлийн байгууллагад байгаа мэдээллийг иргэд цахимаар шалгахын ач холбогдол юу вэ?

-Цахимжилт иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэдэг. Сонгогчдын нэрийн жагсаалтыг цахимаар шалгаснаар тухайн сонгогч өөрийн мэдээллийн зөв эсхүл зөрүүтэй бүртгэгдсэн эсэхийг шуурхай мэдэх, хэрэв зөрүүтэй бол түүнийг шийдвэрлүүлэх цаг хугацаа боломжийг нэмэгдүүлж байна гэж ойлгож болох юм. Өмнө хэлсэнчлэн хаана очиж саналаа өгөхөө хүртэл мэдчихэж болох нь байна.


Улсын бүртгэлийн байгууллагаас үзүүлж байгаа иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн ихэнх үйлчилгээ цахимжсанд

иргэд их талархалтай ханддаг. Энэ ч утгаараа улсын бүртгэлийн байгууллага цахимаар бусад төрийн байгууллагыг манлайлан ажилладаг тэргүүлэгч байгууллага. Та бид хоёрын ярилцаж байгаа сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотойгоор ганц жишээ дурдахад тухайн иргэний хаягт өөр иргэн бүртгэгдсэн байна гэсэн мэдээллийг иргэн өөрөө шалгах боломжийг 2023 оноос эхлүүлсэн. Иргэн Улсын бүртгэлийн байгууллагын burtgel.gov.mn цахим хаягт нэвтэрч www.check.burtgel.gov.mn холбоосоор мэдээллийг шалгах боломжтой. 2024 оны нэгдүгээр сарын 11-ний өдрөөс 2024 оны гуравдугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт 56007 иргэн өөрийн мэдээллийг шалгаснаас 964 иргэн байнга оршин суух хаягт өөр иргэн бүртгэгдсэн байна шалгаж өгнө үү гэсэн хүсэлт гаргасныг харьяалах улсын бүртгэлийн хэлтэст нь шилжүүлсэн байна.

Тухайн иргэний хаягт үл таних хүн бүртгэгдсэн байгаа тохиолдолд Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт "Иргэний оршин суугаа газрын үл хөдлөх эд хөрөнгийн болон газар өмчлөх эрх нь дуусгавар болсон боловч иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь хаягийн бүртгэлд өөрчлөлт ороогүй бол холбогдох иргэний хүсэлтийг үндэслэн гаргасан хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр иргэний байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийг түдгэлзүүлж болно" гэж заасны дагуу эрх бүхий этгээд шийдвэр гаргаж зөрчлийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

-Сонгогчдын нэрийн жагсаалттай нам, эвсэл, нэр дэвшигчид танилцах боломжтой юу?

-Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд орсон өөрчлөлтөөр Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигч, төрийн бус байгууллагын төлөөлөл сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх ажиллагаатай танилцаж болохоор заасан. Тэр дагуу хуульд заасан эрх бүхий этгээд сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх ажиллагаатай танилцаж болно.



Ингэхдээ Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан 2024 оны А/12, А/23 дугаар тушаалаар баталсан "Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаа болон нэрийн жагсаалттай танилцах, ашиглах журам"-ын хүрээнд танилцана. Тодруулбал, сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаатай танилцахад Тагнуулын байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавьж ажиллахаар зохицуулсан.

-Нам, эвсэл, нэр дэвшигчид сонгогчдын нэрийг олшруулж ч юм уу, хууль бусаар ашиглах эрсдэл гарвал яах вэ?

-Хуульд зааснаар сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутгийн хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ. Улмаар дээр дурдсан зөрүүтэй мэдээллийг зассан, сонгогч шилжсэн зэрэг хуульд заасан өөрчлөлтүүдийг тусгаж сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө хэсгийн хороонд хүргүүлэх зохицуулалт байгаа. Үүнээс өөр бусад байдлаар сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх, олшруулах асуудлыг хуулиар хориглосон байдаг. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 20.18 дахь хэсэгт "Сонгогчдын нэрийн жагсаалтыг энэ хуульд зааснаас бусад тохиолдолд хэвлэж тараахыг хориглоно" гэж заасан байгаа. Мэдээж сонгогчдын нэрийн жагсаалтыг хууль бусаар болон иргэний нэг төрийг гутаан доромжлох, иргэний хуулиар хамгаалсан нууцыг бусдад задруулсан зэргээр өөр бусад зорилгоор ашигласан бол хуульд заасан хариуцлага хүлээх ёстой байх.

-Гадаад улсад байгаа иргэдийн бүртгэлийг яаж хийх вэ. Гадаадаас сонгогчдын нэрийн жагсаалтаа шалгаад хаана очиж саналаа өгөхөө мэдэж болох уу?

- Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, хүргүүлэх журмыг Гадаад харилцааны яам, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны А/25 дугаар тушаалаар баталсан.

Гадаад улсад байгаа иргэн гадаад улсад санал авах өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө буюу 6 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө дипломат төлөөлөгчийн газарт сонгуульд оролцохоо мэдэгдэж бүртгүүлсэн байна. Гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг Төв болон салбар комисс зохион байгуулж, ажиллана.

Харин улсын бүртгэлийн байгууллага гадаад улсад санал өгөхөөр бүртгүүлсэн иргэдийн мэдээллийг Төв комиссоос хүлээн авч шалган, улс бүрээр сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэж цахимаар буцаан хүргүүлнэ.

Иргэн гадаад улсад санал өгөхөө мэдэгдэж "Гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх хүргүүлэх журам"-ын хавсралтаар баталсан маягтын дагуу хүсэлтээ гаргах ёстой. Уг хүсэлтэд "ТА өөрийн байрладаг улсад байгаа" гадаад улсад байгаа иргэдийн саналаа ажлыг зохион байгуулах Салбар комисс"-ын санал авах байранд саналаа өгөхийг анхаарна уу." гэсэн санамжийг байрлуулсан.

Гадаад улсад санал өгөхөөр бүртгүүлсэн иргэдийн мэдээллийг хүлээн авах сүүлийн хугацаа зургаадугаар сарын 15-ны өдөр. Улсын бүртгэлийн байгууллага иргэдийн мэдээллийг хүлээн аваад Монгол Улсад байнга оршин суух хаягаар бүртгэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтад "гадаад улсад санал өгөхөөр бүртгүүлсэн" гэсэн нэмэлт тэмдэглэгээ хийгдэнэ. Иргэн мэдээллээ улсын бүртгэлийн байгууллагын burtgel.gov.mn цахим хаягт нэвтэрч <http://election.burtgel.gov.mn/> шалгах боломжтой.

-Олон нийтийн хэлдгээр "царцаа нүүлгэх" эрсдэлээс сэргийлж иргэний шилжилт хөдөлгөөнийг сонгуулиас нэлээн өмнө зогсоодог байх. Тэгсэн атлаа сонгогчийн шилжилт хөдөлгөөнийг хийгээд байдаг. Энэ хоёрын ялгаа юу вэ?

-Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг сонгуулийн санал авах өдрөөс 60 хоногийн өмнө буюу 2024 оны дөрөвдүгээр сарын 29-ний өдөр зогсооно.

Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл бол иргэний улсын бүртгэлийн нэг төрөл. Тухайн бүртгэлийг хөтлөхөд хуульд заасан эх нотлох баримт бичиг бүрдүүлдэг. Хэрэв хүсэлт гаргагчийн нотлох баримт бичиг хуулийн дагуу үнэн зөв байгаа бол бид бүртгэлийг хуульд заасан хугацаанд хөтлөх үүрэгтэй. Харин нотлох баримт хууль бус байх тохиолдолд улсын бүртгэгч бүртгэл хөтлөхөөс татгалзана. Тэгэхээр улсын бүртгэлийн байгууллага иргэний хаягт дураараа иргэдийг олноороо шилжүүлээд байдаггүй гэдгийг л ойлгох хэрэгтэй. Шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлэх иргэн хүсэлтээ гаргасан байна. Нотлох баримтыг бүрдүүлсэн байна. Зарим тохиолдолд иргэн өөрийн хаягт ах дүүгээ шилжүүлж авахыг зөвшөөрсөн атлаа дараа нь мартчихсан "миний хаягт манай дүү байна хасаад өг" гэхчлэн өргөдөл хүсэлт гаргасан асуудал бий. Мэдээллийг нягтлаад үзэхээр өөрөө хүсэлтээ гаргаад шилжүүлж авсан асуудал гарч байсан.

Сонгогчийн шилжилт хөдөлгөөн бол тусдаа асуудал. Хуульд тодорхой хэдэн субъект шилжих зохицуулалт тусгагдсан. Тухайлбал, сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, мэдээллийн технологийн даамал, санал авах байр болон сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахаар ажиллаж байгаа цагдаагийн алба хаагч, итгэмжлэгдсэн ажилтнуудыг тухайн байгууллагынх нь албан бичгийг үндэслэн сонгогчийн шилжилт хөдөлгөөн хийнэ. Харин нэр дэвшигч, нэр дэвшигчийн менежер, нэр дэвшигчийн шадар туслагч бол эрх бүхий байгууллагаас олгосон үнэмлэхийг үндэслэн сонгогчийн шилжилт хөдөлгөөнийг хийх юм. Сонгууль зохион байгуулж сонгуулийн хэсгийн хороонд ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдын Үндсэн хуульд заасан сонгох, сонгогдох эрхийг хангаж байгаа л асуудал.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу сонгогч шилжих бол хүсэлтээ улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан, эсхүл улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө гаргаж шийдвэрлүүлсэн байна.

-Ярилцсанд баярлалаа.

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТААС ЮУ МЭДЭХ ВЭ?

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТЫН МЭДЭЭЛЛИЙГ ЯАГААД ШАЛГАХ ЁСТОЙ ВЭ?

Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэн хийдэг.

Сонгуулийн үеэр “Манай хаяг танихгүй хүн байна”, “Миний мэдээлэл огт алга” гэх яриа гардаг. Тиймээс мэдээллийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй иргэнийг бүртгэх зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газар Сонгогчдын нэрийн жагсаалтыг 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж цахим хуудсандаа байршуулсан.

Иргэн Та сонгогчдын нэрийн жагсаалт дахь мэдээллээ шалгаж, зөрүүтэй байвал шийдвэрлүүлээрэй. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд “Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө шалгасан байвал зохино.” гэж заасан байдаг.

МЭДЭЭЛЛЭЭ ХЭРХЭН ШАЛГАХ ВЭ?

- ✓ Та election.burtgel.gov.mn цахим санд регистрийн дугаар эсхүл иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа нийслэл /аймаг/, дүүрэг /сум/, хороо /баг/-ийг сонгож, “шалгах” товчийг дарна.

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТААС ЮУ МЭДЭХ ВЭ?



“шалгах” товчийг дарснаар Таны эцэг /эх/ -ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, нас, хүйс, хаяг, үндсэн хаяг дээрээ байгаа эсэх зэрэг мэдээлэл гарна. Түүнчлэн сонгуулийн тойргийн дугаар, хэсгийн дугаар, санал өгөх байр, тухайн хаягт бүртгэлтэй сонгогчийн тоо гарна. Өөрөөр хэлбэл, мэдээллээ шалгахаас гадна хаана очиж саналаа өгөхөө мэдэж авна гэсэн үг.

Сонгогчийг харах 1

Сонгогчийг харах сонголтыг идэвхжүүлснээр танай хаяг дээр бүртгэлтэй сонгогчдын нэр гарна.

Мэдээлэл зөв

Таны мэдээлэл зөв бол “мэдээлэл зөв” сонголтыг хийнэ.

МЭДЭЭЛЭЛ ЗӨРҮҮТЭЙ БОЛ ЯАХ ВЭ?

1.

Мэдээлэл зөрүүтэй

Хэрвээ Таны мэдээлэл зөрүүтэй бол аль зөрүүтэй мэдээллийн арын сумыг дарж идэвхжүүлнэ. Тухайлбал, хаяг зөрүүтэй бол "дэлгэрэнгүй хаяг" мэдээлэл, танай хаягт бүртгэлтэй сонгогчийн тоо зөрүүтэй бол "хаягт бүртгэлтэй сонгогчийн тоо" гэсэн мэдээллийн арыг идэвхжүүлнэ гэсэн үг. Ингэснээр "мэдээлэл зөрүүтэй" хэсэг улаан болж, дарахад идэвхэжнэ.



2.

"мэдээлэл зөрүүтэй" хэсэг дээр дарснаар утасны дугаар, и-мэйл хаяг, нэмэлт тайлбар бичих цонх гарч ирнэ. Эдгээр цонхон дээр мэдээллээ бичиж, "илгээх" сонголт хийнэ.

Илгээх

3.

"илгээх" сонголт хийснээр "Таны зөрүүтэй мэдээллийг шалгуулахаар ... дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст шилжүүлээ. Баярлалаа" гэсэн мэдээлэл гарна. Таны мэдээллийг бүртгэлийн байгууллага шалгаж, холбогдох хариуг өгөх болно. Мөн Улсын бүртгэлийн байгууллагад биечлэн хандаж засуулж болох аж.

Баярлалаа



дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст таны мэдээллийг бүртгэлийн байгууллага шалгаж, холбогдох хариуг өгнө

“ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ”

СОНГУУЛЬД ОРОЛЦОЖ БУЙ УЛС ТӨРИЙН НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙГ СУДАЛЖ БАЙЖ САНАЛАА ӨГДӨГ

МӨРИЙН ХӨТӨЛБӨР ГЭЖ ЮУ ВЭ ?

Сонгуулийн тухай хууль тогтоомжоор сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжих сонгуулийн мөрийн хөтөлбөртэй. Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь зөвхөн сонгуульд зориулсан, ялахын төлөө биш харин улс орны болон тухайн орон нутгийн хүний хөгжил, олон нийтийн нийтлэг эрэлт хэрэгцээг тусгасан, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хугацаа, арга зам, хэрэгжүүлэх төлөвлөгөөг хамтад нь багтаасан, хууль тогтоомжид заасан тодорхой шаардлагыг хангасан, бодлогын баримт бичиг байдаг. Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ нь улс орны урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээ хэрэгжүүлэхээр бол шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд энэ талаар төрийн аудитын дээд байгууллага хянаж, дүгнэлт гаргадаг байна.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР ЯАГААД ЧУХАЛ ВЭ ?

Улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид улс оронд болон тухайн тойрогт нь тулгамдаж буй асуудлын талаар судалгаа, дүн шинжилгээ хийж, үүнийхээ үр дүнд тэдгээрийг сайжруулах арга замыг мөрийн хөтөлбөртөө тусгадаг. Улсын Их Хурлын сонгуулийн тухайд сонгуулиар олонх суудал авсан нам, эвслийн мөрийн хөтөлбөр нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндэс болдог тул сонгогчид мөрийн хөтөлбөрийг нь судалж үзэж байж сонголтоо хийдэг. Өөрөөр хэлбэл, ямар асуудлыг дэвшүүлэв, түүнийг хэрхэн сайжруулна гэж амлав, тэр нь үнэхээр хэрэгжих боломжтой, бодит байдалд нийцэж байна уу гэдгийг авч үздэг. Иймд сонгуулийн мөрийн хөтөлбөр нь сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны үндэс болдог, нөгөө талаас сонгогчид сонголтоо хийхэд шийдвэрлэх нөлөө үзүүлдэг.



Та “Хариуцлагатай сонгогч” байж сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн дэвшүүлж буй мөрийн хөтөлбөрүүдийг харьцуулан судлахдаа дараах үндсэн асуудлыг хэрхэн шийдвэрлэх, түүнийг шийдвэрлэхдээ хэр бодитой, үндэслэлтэй, хэрэгжихүйц санал дэвшүүлж байгааг тунгаагаарай.

	Боловсролын чиглэлээр:	>	Цэцэрлэг, ерөнхий боловсролын болон мэргэжлийн, их дээд сургуулийн хүртээмж, боловсролын чанар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэгш хамруулалт, насан туршийн боловсрол олгох, оюутны тэтгэлэг, сургалтын хөтөлбөр гэх мэт
	Эрүүл мэндийн чиглэлээр:	>	Эмч, эмнэлгийн хүртээмж, үйлчилгээний чанар, эм, эмчилгээний чанар, хангамж, хөнгөлөлт, эрүүл мэндийн даатгалын бодлого, спортыг дэмжих, хөгжүүлэх гэх мэт
	Эдийн засгийн чиглэлээр:	>	Ажилгүйдэл, татвар, жижиг дунд бизнесийг дэмжих бодлого, хувийн хэвшлийг дэмжих бодлого, ажлын байрны баталгаа, хямралыг арилгах бодлого, олон улсын зээл, тусламж гэх мэт
	Нийгмийн чиглэлээр:	>	Нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн янз бүрийн давхаргын хүмүүс болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нэн ядуу хүмүүсийг хамарсан бодлого, өндөр настан, гэр бүл, эх нялхас, хүүхдэд ээлтэй бодлого, халамж, үйлчилгээ гэх мэт
	Соёлын чиглэлээр:	>	Соёл урлагийг хөгжүүлж, уламжлалт бичиг соёл, түүхээ сурталчлан таниулах, дэмжих талаар бодлого, үйл ажиллагаа
	Дэд бүтцийн чиглэлээр:	>	Барилга, зам, харилцаа, холбоо, техникийн хөгжил, дэвшил, явган хүний зам, тоглоомын талбай, байр хоорондын тохижилт, аж үйлдвэр, уурхай, нөхөн сэргээлтийн асуудал гэх мэт



ТА “ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ” БАЙЖ СОНГУУЛИЙН ӨДРӨӨС ӨМНӨ МӨРИЙН ХӨТӨЛБӨРТЭЙ ХОЛБООТОЙ ДАРААХ ШАЛГАХ АСУУЛТЫГ ӨӨРТӨӨ ТАВИАРАЙ.

Шалгах асуулт	Хийх үйлдэл	Миний хариулт
6 дугаар сарын 28-ны өдөр бид ямар байгууллага, албан тушаалтныг сонгох вэ?	Төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлыг сонгож байгуулна. Энэ сонгуулиар 126 Улсын Их Хурлын гишүүнийг сонгох бөгөөд 78 гишүүнийг 13 сонгуулийн тойргоос, үлдэх 48 гишүүнийг улс төрийн намын жагсаалтаар сонгоно.	
Сонгуулиар байгуулах Улсын Их Хурал нь ямар бүрэн эрхийг хэрэгжүүлдэг вэ?	“Бид энэ удаагийн сонгуулиар ямар байгууллагыг сонгох гэж байна”, “Тухайн байгууллага нь ямар эрх, үүрэгтэй байгууллага вэ” гэдгийг ойлгож, мэдвэл мөрийн хөтөлбөрт илүү хариуцлагатай хандаж, сонголтоо ч хариуцлагатай хийж чадна. Тиймээс Улсын Их Хурлын хэрэгжүүлдэг чиг үүргийг судална уу.	
Та нам, эвсэл, нэр дэвшигч бүрийн мөрийн хөтөлбөртэй танилцсан уу?	Та сонголтоо хийхийн тулд тойрогтоо өрсөлдөж байгаа нам, эвсэл, нэр дэвшигч бүрийн мөрийн хөтөлбөртэй танилцах хэрэгтэй. Манай намын гишүүн, эсвэл боловсролтой, туршлагатай, таньдаг, хөрөнгөтэй, “нүд дүүрэн, сайхан” байх зэрэг нь таны хийх гэж буй сонголтын шалгуур огтхон ч биш. Хийх гэж буй ажлыг нь, мөрийн хөтөлбөрийг нь, итгэл даах чадварыг нь харьцуулж үнэлнэ үү.	
Мөрийн хөтөлбөрт тусгахыг хориглосон зүйлс нам, эвсэл, нэр дэвшигчийн хөтөлбөрт байгаа эсэхийг судалсан уу?	Мөнгө, эд хөрөнгөтэй холбоотой эрх олгох, зээлийн болон бусад өр төлбөрийг хүчингүйд тооцох, ажлын байранд зуучлах зэрэг сонгогчдын саналыг худалдан авахад чиглэсэн аливаа амлалтыг мөрийн хөтөлбөрт тусгахыг хуулиар хориглодог. Хариуцлагатай нэр дэвшигчид хуулийг ягштал мөрдөж ажилладаг тул мөрийн хөтөлбөр нь хуульд нийцсэн эсэхийг нягтална уу.	
Нам, эвсэл, нэр дэвшигч бүрийн мөрийн хөтөлбөрийг “хэрэгжүүлэх бүрэн эрх”-тэй нь харьцуулж үнэлсэн үү?	Хэрвээ мөрийн хөтөлбөрт тухайн сонгогдох албан тушаалтны бүрэн эрхэд нь хамааралгүй үйл ажиллагаа, амлалт тусгагдсан бол энэ нь таны саналыг татах зорилготой “Биелэх боломжгүй хуурамч амлалт” гэж ойлгоно уу.	
Санал болгож буй мөрийн хөтөлбөр нь бодит байдалтай нийцсэн, хэрэгжих боломжтой санагдаж байна уу?	Мөрийн хөтөлбөр нь зөвхөн сонгуульд зориулсан, ялахын төлөө ашиглах хэрэглэгдэхүүн биш харин улс орны болон тухайн орон нутгийн хүний хөгжил, олон нийтийн нийтлэг эрэлт хэрэгцээг тусгасан, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хугацаа, арга зам, хэрэгжүүлэх төлөвлөгөөг хамтад нь багтаасан, хууль тогтоомжид заасан тодорхой шаардлагыг хангасан бодлогын баримт бичиг гэдгийг дахин санана уу.	



Сонгогч та мөрийн хөтөлбөртэй холбоотой асуулт, лавлах зүйл байвал “Сонгогчийн лавлах утас” болох **1800-2800** утас болон **“Сонгох өдөр”** фэйсбүүк хуудсанд хандаарай. Танд бид туслахад бэлэн байна.

Сонгогчдын Боловсрол Төвөөс бэлтгэв.



ИРГЭНИЙ СОНГОХ ЭРХИЙГ ХАНГАХААР УУЛ УУРХАЙН КОМПАНИУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар үндсэн хаягаасаа өөр газар ажиллаж байгаа болон гадаад улсад амьдарч байгаа иргэдийн сонгох эрхийг хангах чиглэлээр хэрхэн ажиллаж байгаа талаар Сонгуулийн ерөнхий хорооны Улс төрийн намын санхүүжилт, хяналтын газрын дарга Н.Булгамаагаас тодрууллаа.

-Гэрээсээ хол, өөр аймагт удаан хугацаагаар ажиллаж байгаа иргэд сонгох эрхээ эдэлж, сонгуульд оролцоход хүндрэлтэй байдаг. Улсын хэмжээнд хэчнээн хүн байнга оршин суугаа хаягаасаа өөр газар ажилладаг юм бэ?

-Иргэний сонгох, сонгогдох эрхийг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх чиглэлээр Сонгуулийн ерөнхий хороо Хүний эрхийн үндэсний комисстой хамтран ажиллах төлөвлөгөө батлаад ажиллаж байна. Төлөвлөгөөний чухал хэсэг нь байнга оршин суугаа хаягаасаа өөр газар ажиллаж байгаа болон гадаад улсад суугаа иргэдийн сонгох эрхийг хангах юм.

Байнга оршин суугаа газраасаа өөр газар ажилладаг иргэдийн олонхыг ачаа тээвэр болон уул уурхай компанийн ажилчид эзэлдэг. Тухайлбал, Өмнөговь аймгийн Гашуун-сухайт боомтод 419 аж ахуйн нэгжид 17.4 мянга, Шивээ-хүрэн боомтод 104 аж ахуйн нэгжийн гурван мянга гаруй, Ховд аймгийн Булган боомтод 42 аж ахуйн нэгжийн 500 гаруй, Сүхбаатар аймгийн Бичигт боомтод 30 аж ахуйн

нэгжийн 500 гаруй, Дорноговь аймгийн Ханги боомтод 77 аж ахуйн нэгжийн 1100 гаруй, Дорноговь аймгийн Замын-Үүд боомтод 223 аж ахуйн нэгжийн 900 гаруй, Дорнод аймгийн Баянхошуу-Өвдөг боомтод 4 аж ахуйн нэгжийн 100 гаруй жолооч ажиллаж байгаа талаарх судалгааг Зам тээвэр, хөгжлийн яамнаас ирүүлсэн.

Эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд, ажиллах хүчний тоог харьцуулахад, 200 хүртэлх ажилчинтай 527, 500 хүртэл ажиллагсадтай 25, 1000 хүртэл ажиллагсадтай зургаа, 1000-аас дээш ажиллагсадтай 7 аж ахуйн нэгж, байгууллага байна. 292 аж ахуйн нэгж, байгууллагаас 3 нь мянгаас дээш, 273 нь 200 хүртэл гэрээт ажиллагсадтай гэдэг судалгаа гарсан.

Нийтдээ 295 аж ахуйн нэгжийн 38,258 үндсэн ажиллагсдын 19743 орон нутгаас, 18515 бусад газраас, 29,657 гэрээт ажиллагсдын 7,583 нь орон нутгаас болон 22,074 ажиллагсад бусад газраас ажилладаг байна.

“

УЛСЫН ИХ ХУРЛЫН
СОНГУУЛИЙН ТУХАЙ
ХУУЛИАС...

66.16.САНАЛ
АВАХ ӨДӨР
АЖИЛЛАЖ БАЙГАА
СОНГОГЧИД ТУХАЙН
БАЙГУУЛЛАГЫН
УДИРДЛАГА ЧӨЛӨӨ
ОЛГОЖ, ТҮҮНИЙГ
САНАЛ ӨГӨХ
БОЛОМЖООР ХАНГАХ
ҮҮРЭГТЭЙ.

-Тухайн орон нутагт очиж ажиллаж байгаа иргэний сонгох эрхийг хэрхэн хангах вэ?

-Сонгуулийн ерөнхий хорооны ажилтнууд долоон багт хуваагдаж орон нутагт ажиллахдаа Хүний эрхийн үндэсний комиссын орон нутаг дахь ажилтнуудтай хамтран Засаг даргын Тамгын газар, Иргэдийн хурлын нарийн бичгийн дарга, тухайн орон нутгийн Улсын бүртгэлийн газар, цагдаагийн газар, уул уурхайн компани, аж ахуйн нэгжийн удирдлагуудтай уулзаж, сургалт хийсэн.

Уул уурхайн компаниуд орон нутгийн удирдлагуудтай нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэх гэрээтэй ажилладаг юм байна. Ажилчдынхаа сонгох эрхийг хангах чиглэлээр гэрээндээ тодорхой тусгаж, хэрэгжилтийг хангахыг орон нутгийн удирдлагуудад зөвлөсөн. Тухайлбал, Өмнөговь аймгийн Ханбогд суманд байрлах “Оюу толгой” ХХК-ийн орон нутгийн харилцааны төлөөлөл, хэлтсийн менежертэй уулзаж, сонгох эрхийг хангах талаар мэдээлэл солилцож, хамтран ажиллахаар болсон. Тус компанийн хувьд 17800 орчим монгол хүн ажилладгаас 15900 нь байнга оршин суугаа газраасаа өөр буюу Ханбогд суманд очиж ажилладаг. Тэдгээр ажиллагсад тэгш болон сондгой хуваариар, менежерүүд даваагаас баасан гаригт ажиллана, тасралтгүй үргэлжлэх, зайлшгүй шаардлагатай ээлжийн ажилтан ажиллана гэх зэргээр тооцоход дээрх тоо 50 хувиас буурч тооцогдоно. Иймд санал өгөх өдөртэй давхцуулж ээлж солих, мөн тухайн өдрийн онгоц, унаа, тээврийн асуудлыг зохицуулах, тухайн өдөр ажилласнаар тооцож цалин хөлсийг олгох зэргээр сонгох эрхийг нь хангаж, хууль хэрэгжүүлэх талаар ярилцаж байна. Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх хүрээнд ажил эхлэхийн өмнө өгдөг зааварчилгаа болон сургалт мэдээллийн цаг дээр сонгуулийн боловсрол, сонгогчийн мэдлэгийг нэмэгдүүлэх хичээл, сургалт, мэдээлэл түгээж байгаа.

-Сонгуулийн өдөр ажилтнууддаа чөлөө олгох нь хуульчилсан байдаг байх аа?

-Ажилтан, албан хаагчдынхаа сонгох эрхийг хангах нь ажил олгогчдын хуулиар хүлээсэн үүрэг.

-Гадаадад байгаа иргэдийнхээ сонгох эрхийг хангах, идэвхжүүлэх чиглэлээр хэрхэн ажиллаж байна вэ?

-Гадаадад байгаа иргэдийнхээ сонгох эрхийг хангах, идэвхтэй оролцуулах тал дээр Дипломат төлөөлөгчийн газрууд, монголчууддаа зориулсан үйл ажиллагаа явуулдаг ТББ-тай мэдээ, мэдээлэл түгээх чиглэлээр хамтран ажиллаж байна. Дипломат төлөөлөгчийн газрын цахим сайтаар санал өгөх заавар мэдээллүүд хүргэнэ. Тухайлбал: НҮБ-ын Шилжилт, хөдөлгөөний байгууллагатай хамтран хилийн чанад дахь иргэдэд чиглэсэн сонгуулийн болон сонгогчийн боловсрол дээшлүүлэх контент бэлтгэж, хүргэхээр ажиллаж байна. Мөн тус байгууллагаас зохион байгуулсан Диаспора нээлттэй форумд оролцож, гадаад улсад байгаа иргэдэд мэдээлэл хүргэсэн. Энэ мэдээлэл нь олон улсад монголчуудын групп, мэдээллийн хэрэгслээр шууд хүрсэн.



П.АЛТАНЧИМЭГ:

ГАДААДАД БАЙГАА ИРГЭД САНАЛ ӨГӨХӨӨ ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАРТАА МЭДЭГДЭНЭ

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар гадаад улсад байгаа иргэдээс хэрхэн санал авах талаар Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн ахлах референт П.Алтанчимэгтэй ярилцлаа.

-Гадаад улсад байгаа иргэдээс санал авах бэлтгэл ажил хэрхэн хангагдаж байна вэ?

-Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар **6 ДУГААР САРЫН 20, 21, 22, 23-НЫ ӨДРҮҮДЭД** гадаад улсад байгаа иргэдээс санал авахаар тогтоосон.

Сонгуулийн ерөнхий хороо Гадаад хэргийн яамны саналыг харгалзан гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэгтэй Төв комиссыг байгуулсан.

Төв комисс гадаад улсад байгаа иргэдийн санал авах

ажлыг төлөвлөж, түүнийг зохион байгуулах арга хэмжээг авч ажиллана. Энэ хүрээнд Төв комисс Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын дэргэд тухайн улсад санал хураалтыг зохион байгуулах үүрэг бүхий салбар комиссыг байгуулан ажиллах юм.

Салбар комисс тухайн улсад суугаа иргэдэд санал авах байрны хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг мэдээлэх үүрэгтэй. Мөн сонгуульд оролцох сонгогчдын бүртгэлийг хийх болон сонгогчдоос санал авах ажлыг гардан зохион байгуулдаг.

-Улсын Их Хурлын 126 гишүүнийг сонгуулийн тойргоос олныг төлөөлөх (мажоритар), хувь тэнцүүлэн төлөөлөх (пропорционал) аргаар сонгоно. Гадаад улсад байгаа иргэдийн хувьд яах билээ.


-Улсын их хурлын 2024 оны ээлжит сонгуулиар сонгуулийн холимог тогтолцоогоор 126 гишүүн сонгоно. 78 гишүүнийг бүсчилсэн 13 том тойргоос олныг төлөөлөх аргаар сонгох бол 48 гишүүнийг Улс нэг тойрог бүхий хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох юм. Гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэд хувь тэнцүүлэх хэсэгт нам, эвсэлд саналаа өгснөөр Улсын Их Хурлын 48 гишүүнийг сонгоход өөрийн саналыг өгч сонгуульд оролцоно.

-Санал өгөхдөө дээр дурдсан дөрвөн өдрийн аль нэгт нь очиход болох уу. Сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа эсэхээ урьдчилж шалгах шаардлага бий юү?






**СОНГУУЛЬД ОРОЛЦОХОО
МЭДЭГДЭЖ, БҮРТГҮҮЛНЭ.**



**ӨДРҮҮДЭД БУЮУ 4 ХОНОГИЙН
ХУГАЦААНД АВНА
07:00-22:00**



**тухайн улсын орон
нутгийн цагаар
07:00-22:00 цаг
хүртэлх хугацаанд
салбар комиссын
тогтоосон санал
авах байранд авна.**

-Гадаад улсад суугаа иргэдийн хувьд санал өгөх процесс нь Монгол Улсад санал өгөхөөс бага зэргийн ялгаатай.

НЭГДҮГЭЭРТ, Урьдчилан бүртгүүлнэ. Иргэд өөрийн суугаа орныхоо дипломат төлөөлөгчийн газар буюу салбар комисст 6 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө сонгуульд оролцохоо мэдэгдэж, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгүүлэх хүсэлтээ гаргана. Мөн санал хураалтын өдрөөс өмнө сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхийг шалгах хэрэгтэй.

ХОЁРДУГААРТ, Саналын хуудсаа дугтуйлж битүүмжилнэ. Сонгогч та 6 дугаар сарын 20, 21, 22, 23-ны өдрүүдэд тухайн Улсынхаа цагаар 07:00-22:00 хүртэл Дипломат төлөөлөгчийн газарт байрлах санал авах байранд иргэний үнэмлэх эсвэл үндэсний гадаад паспортыг авч очин саналаа өгнө.

Санал авах байранд сонгогчийн иргэний үнэмлэх эсвэл үндэсний гадаад паспортыг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган үзэж саналын хуудас, дугтуйн хамт өгдөг.

Сонгогч санал тэмдэглэх бүхээгт орж саналын хуудас дээрх зааврын дагуу саналаа тэмдэглэж дугтуйд битүүмжлээд саналын хайрцагт хийж саналаа өгнө.

-Дипломат төлөөлөгчийн газар гэдгээ тодруулаач.

-Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Олон улсын байгууллагын дэргэд суугаа Монгол Улсын Байнгын Төлөөлөгчийн газар, Монгол Улсын Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газруудыг нийтэд нь Дипломат төлөөлөгчийн газар гэж ойлгож болно. Дээрх дурдсан газруудад тухайн улсад суугаа Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдээс санал авах салбар комисс байгуулагдан санал хураалтыг зохион байгуулна.

Гадаад хэргийн яамны цахим хуудас [/https://consul.mn/](https://consul.mn/) /-т мэдээлснээр 2024 оны дөрөвдүгээр сарын байдлаар 49 орчим дипломат төлөөлөгчийн газар Монгол Улсаас хилийн чанадад байна.

-Сонгуульд санал өгөхөө мэдэгдэхдээ заавал биечлэн очих уу?

-Гадаад улсад суугаа иргэд өөрийн байгаа улсынхаа Дипломат төлөөлөгчийн газарт биечлэн, шуудан, эсхүл цахим шуудангаар сонгуульд оролцохоо мэдэгдэж бүртгүүлэх боломжтой. Сонгуулийн ерөнхий хорооноос аль болох уян хатан байдлаар бүртгэлийг зохион байгуулж гадаад улсад суугаа иргэдийн сонгох эрхийг хангаж ажиллахаар зорьж байна.

Санал хураалт болоод урьдчилан бүртгүүлэх талаар нарийн зааварчилгаа мэдээллүүдийн дипломат төлөөлөгчийн газруудаараа дамжуулан түгээх болно.

-Дипломат төлөөлөгчийн газаргүй улсад амьдарч байгаа монголчууд яаж саналаа өгөх вэ?

-Санал өгөхөө урьдчилан мэдэгдээд өгөхдөө өөрт ойр, хил залгаа улсын Дипломат төлөөлөгчийн газарт очоод санал өгөх боломжтой.

-Гадаадад амьдарч байгаа Монголчуудын хувьд тухайн улсынхаа хөдөлмөрийн хуулийн дагуу ажилладаг учраас санал өгөх өдрөө ажлаасаа чөлөө авах эрхийг хэрхэн эдлэх бололцоог хэрхэн хангах вэ?

-Санал хураалтын өдрийг аль болох олон өдөр болгох, амралтын өдрийг тааруулах боломжтой байх саналуудыг Сонгуулийн ерөнхий хорооноос хууль тогтоогчид хүргүүлсэн. Энэ дагуу дээр хэлсэн ДӨРВӨН өдрийн аль нэгэнд нь саналаа өгөх боломжийг бүрдүүлсэн.

-Гадаад улсад байгаа иргэдийн саналаа өгсөн хуудсыг хэрхэн тоолж, баталгаажуулж хүчинтэйд тооцох вэ?

-Салбар комисс нь санал хураалт дууссаны дараа битүүмжилсэн дугтуйтай саналын хуудсыг Төв комиссоор дамжуулан Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

Сонгуулийн ерөнхий хороо гадаад улсаас ирсэн саналын хуудсыг өөрийн байранд 6 дугаар сарын 28-ны өдрийн 22:00 цагаас эхлэн тоолох үйл ажиллагааг зохион байгуулна. Өөрөөр хэлбэл, салбар комиссуудаас ирсэн битүүмжлэл бүхий саналын хуудсыг нэг бүрчлэн задалж, санал тоолох төхөөрөмжид уншуулан дүнг гаргадаг. Уг үйл ажиллагаанд ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна.

- Ер нь гадаадад байгаа иргэдийн сонгуулийн идэвх, оролцоо ямар байдаг вэ?

-Манай улс гадаад улсад суугаа иргэдийнхээ саналыг хамгийн анх Монгол Улсын Их Хурлын 2012 оны ээлжит сонгуулиар хувь тэнцүүлсэн хэсэгт сонгогч нам, эвслийг дэмжиж саналаа өгөх боломжтойгоор зохион байгуулсан. Үүнээс хойш Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013, 2017, 2021 оны ээлжит сонгууль гээд нийт 4 удаагийн сонгуульд гадаад улсад суугаа иргэдийн саналыг авах үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

Сонгогчдын оролцооны хувьд 4000-7400 орчим сонгогч бүртгүүлж, тэдний 2700-5600 орчим нь саналаа өгсөн. Өөрөөр хэлбэл, сонгуульд оролцохоо илэрхийлсэн хүмүүсийн олонх нь саналаа өгдөг.

Гадаад дахь сонгогчдын санал хураалтад оролцсон байдал

№	Сонгуулийн нэр	Он	Салбар комисс	СНЖ-д бүртгүүлсэн	Санал өгсөн	СНЖ-тай харьцуулахад
1	Улсын Их Хурлын сонгууль	2012	39	4276	2777	65%
2	Ерөнхийлөгчийн сонгууль	2013	39	6233	4242	68.1%
3	Ерөнхийлөгчийн сонгууль-I	2017	45	7209	4767	66.13%
4	Ерөнхийлөгчийн сонгууль -II	2017	42	7209	2676	37.12%
5	Ерөнхийлөгчийн сонгууль	2021	45	7394	5568	75.3%

Гэхдээ санал өгөхөө илэрхийлж бүртгүүлсэн сонгогчдыг Монгол Улсаас гадаад улсад суугаа нийт иргэдийн тоотой харьцуулахад харьцангуй бага буюу хангалтгүй хэмжээнд байгаа юм.

Үндэсний статистикийн газрын хүн амын 2020 оны тооллогын дүнгээр 122,301 иргэний 82 хувь нь сонгуулийн насны иргэн байсан. Эндээс харахад Монгол Улсаас гадаад улсад суугаа нийт сонгуулийн насны иргэдийн 3-6 хувь л нь сонгуульд оролцож сонгох эрхээ эдэлсэн байна.

Гадаад улсад байгаа иргэдийнхээ сонгох эрхийг хангахын тулд багагүй төсөв хөрөнгө, хүн хүч зарцуулдаг. Тиймээс иргэнийхээ үүргийг биелүүлээд саналаа өгөөрэй гэж уриалмаар байна.

-Ер нь бусад улсууд өөр оронд байгаа иргэдийнхээ саналыг хэрхэн авдаг вэ?

-Ардчилал, сонгуульд туслалцаа үзүүлэх олон улсын хүрээлэн /IDEA international/ -гийн судалгаагаар дэлхийн 216 улсаас 150 улс гадаад улсад суугаа иргэдийнхээ саналыг авдаг буюу сонгох эрхийг хангаж ажиллаж байна. Мэдээж манай улс энэ тоонд орно.

Харин арга хэлбэрийн тухайн эдгээр улсууд санал авах байранд өөрийн биеэр ирж санал өгөх, шуудангаар санал өгөх, цахим системээр санал өгөх болон итгэмжлэгдсэн ажилтнаар дамжуулан санал өгөх гэсэн арга хэлбэрүүдийг хэрэглэж байна. Дээрх улсууд гадаад улсад суугаа иргэдэд санал өгөх аль болох олон арга хэлбэрийг санал болгож байна. Жишээлбэл, Шинэ Зеланд улсын хувьд гадаад улсад суугаа иргэд цахим системээр санал өгөх, өөрийн биеэр санал өгөх болон шуудангаар санал өгөх гэсэн гурван хэлбэрээс сонгогч өөрт тохиромжтой хэлбэрийг сонгож санал өгөх боломжтой байдаг юм билээ.



ГАДААД УЛСАД БАЙГАА ИРГЭД САНАЛАА ӨГНӨ...



"London School of Economics and Political Science" Их сургуулийн
Хүний эрх ба улс төрийн магистрант
С.ГАНДОЛГОР

Улсын Их Хурлын энэ удаагийн сонгууль онцлог, хуульд томоохон өөрчлөлт орсон шүү дээ. Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүдийн тоог 128 болгосноос гадна сонгуулийн холимог тогтолцоо нэвтрүүлсэн. Гадаадад байгаа монголчууд пропорциональ буюу сонгуульд оролцож байгаа улс төрийн нам, эвсэлд саналаа өгөх боломжтой болсон. Ингэснээр Улсын Их Хуралд намын жагсаалтаар орох 48 гишүүдийг сонгоход бид хувь нэмрээ оруулна гэсэн үг. Гадаадад байгаа монголчууд улс, эх орныхоо хөгжил, үйл явдалд оролцож чадахгүй болоод ч тэр үү илүү бухимдалтай, сэтгэл зовнисон харагддаг. Цахим сүлжээ хөгжсөн энэ цагт бид онлайн оролцож,

санал бодол, сэтгэгдлээ хуваалцсан ч төдийлөн шийдвэр гаргах түвшинд хүрдэггүй. Тэгвэл улс төрийн нам, эвсэл сонгох замаар 48 гишүүнийг сонгож, шийдвэр гаргах түвшинд шууд оролцож, ирээдүй хойч үедээ сайхан нийгмийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах юм. Хэдийгээр өөр улсад амьдарч, суралцаж байгаа ч Танд чухал асуудлын төлөө саналаа өгч улс, эх орны хувь заяа хэрхэх, нийгэм, ард иргэд, хөгжилд тустай асуудлын төлөө дуугарах боломж юм. Бид дэлхийн аль өнцөг, буланд байхаас үл шалтгаалан энэхүү боломжийг ашиглан дуу хоолойгоо өргөж, итгэл үнэмшил, эх орныхоо төлөө САНАЛАА ӨГЬЕ!

Олон жил эх орноосоо алс хол амьдран суугаа ч цохилох зүрх, санах сэтгэл нутаг руугаа үргэлж чиглэдэг. Эх орныхоо хөгжил дэвшлийн төлөө сэтгэл, оюунаа зориулах зөв удирдагч, зөв манлайлагч төрөн гарахад бид бүхний сонгуульдаа орох идэвх зүтгэл ихээхэн шалтгаална. Хэдийгээр эх орондоо аж төрөн суугаагүй ч сонгуульдаа идэвхтэй оролцохыг чин сэтгэлээсээ хүсэн, уриалж байна.



Япон улс, Осака
хот, сэтгүүлч
Х.ЭРДЭНЭЦЭЦЭГ:



МҮХАҮТ-ын Ши-Ань хот дахь
төлөөлөгч, Ши-Ань Жиаотун
их сургуулийн докторант
М.ДЭЛГЭРЖАРГАЛ:

Гадаад улсад ажиллаж, амьдарч буй монголчуудын хувьд тэр бүр улс орныхоо үйл хэрэгт шууд оролцох боломж байдаггүй ч хууль тогтоох дээд байгууллага, Улсын Их Хурлын ээлжит сонгуульдаа оролцож, санал өгөх боломж энэ жил тохионо. Үндсэн хуулиар олгогдсон сонгох эрхээ эдэлж, сонгуулийн өдөр Бээжин хот дахь Элчин сайдын яамандаа очиж

саналаа өгнө гэж төлөвлөж байгаа. Сонгуулийн санал өгөх газар нь өөр хот, өөр мужид хол байдаг шалтгаан ч юм уу, миний л саналаар дутаг гэсэн хандлагаар бус Монгол Улсын иргэний сонгох эрхээ эдэлж, улс орныхоо үйл хэрэгт оролцох боломжоо ашиглан саналаа идэвхтэй өгөхийг уриалж байна.



Олон улсын эрүүгийн шүүхийн ахлах
өмгөөлөгч **Н.ОРЧЛОН:**

Насанд хүрсэн сонгуульд саналаа өгдөггүй бол том хүн болоогүй л байна гэсэн үг. Биеийн хувьд төдийгүй сэтгэлгээний хувьд насанд хүрсэн хүн ирээдүйгээ бодитоор хардаг учраас сонгуульд идэвхтэй ханддаг юм билээ. Тэд өөрийнх нь сонголт өөрийнх нь, улс орны ирээдүйд ч хэрэгтэй гэдгийг мэддэг. Тийм учраас цаг заваа гаргаж, зорьж байгаад саналаа өгөхдөө түүртдэггүй. Насанд хүрсэн хүн ажил хийдэг, үүрэг хариуцлага хүлээдэг.

Үүнтэй ижил сонгуульд саналаа өгөхийг насанд хүрсэн хүний хийх ажил гэж хардаг.

Өөрийгөө том хүн болсон гэж бодож байгаа бол сонгуулиа өгцгөө гэж уриалмаар байна. Манай улс ардчилсан орон учраас сонгуулийн саналаараа өөрчлөлтийг хийж болдог. Өөрчлөлт хийх боломжтойг мэдсээр байж саналаа өгөхгүй байна гэдэг балчир хүүхдийн л сэтгэлгээ шүү дээ.

ОНУМН
СУДАЛГААНЫ САН

СОНГУУЛЬ 2024



VI.28 07⁰⁰–22⁰⁰

ГАДААД УЛС ДАХЬ СОНГУУЛЬ

VI.20, 21, 22, 23

07⁰⁰ – 22⁰⁰





ТА ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ


Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсад Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж заасан байдаг. Сонгуульд оролцож, саналаа өгнө гэдэг нь төрийн эрх барих эрх, эрх чөлөөгөө эдэлж буй хэрэг. Монгол Улсын иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, төлөөллийн байгууллагыг өөрсдөө бүрдүүлж байгаа үндсэн арга нь сонгууль. Бидний өдөр тутмын амьдрал эдгээр сонгуулиар бий болдог төр засгийн байгууллагууд болон тэдний гаргадаг бодлого, шийдвэрээс ямагт хамааралтай байдаг. Сонгуульд оролцоно гэдэг нь бид бүхэн өөрсдийн санаа бодол, хүсэл зоригийг төрийн бодлого, шийдвэрт тусгуулах гол алхам бөгөөд өөрсдөдөө ээлтэй ирээдүйг бий болгож, хүсэж байгаа сайхан амьдралаа бүтээхийн тулд сонгогч идэвх, оролцоогоо нэмэгдүүлэхээс эхэлнэ. Өөрөөр хэлбэл, сонгуульд оролцож, саналаа өгөхгүй бол таны хүсэл зориг төрийн бодлого, шийдвэрт тусгалаа олж чадахгүй юм.

Тиймээс сонгуульд оролцож байгаа нам, нэр дэвшигчийн бодлого, мөрийн хөтөлбөрийг судалж, харьцуулж, сонгуулийн үйл явцад идэвхтэй оролцож, саналаа өгөх нь бид өөрсдийнхөө төлөө хийж байгаа хамгийн хариуцлагатай алхмын нэг болно. Сонгуулийн эрх бүхий иргэн бүр төрийн үйл хэрэгт оролцох эрхээ эдэлж, сонгуульд идэвхтэй хандаж, саналаа өгч, хувь нэмрээ өгөх чухал ач холбогдолтой үе ирээд байна.

СОНГОГЧ САНАЛАА ХЭРХЭН ӨГӨХ ВЭ?

Сонгуулийн санал авах өдөр бүх нийтээр амрах өдөр байдаг. Хэрвээ сонгуулийн санал авах өдөр ажиллаж байгаа сонгогч байвал байгууллагынх нь захиргаа чөлөө олгож, саналаа өгөх боломжоор хангах үүрэг хүлээдэг. Сонгуулийн санал авах өдөр саналаа өгөх боломжгүй зарим сонгогчдын саналыг зөөврийн битүүмжилсэн хайрцгаар авдаг тусгай журам бий. Тухайлбал, эрүүл мэндийн байдлын улмаас санал авах өдөр санал авах байранд биечлэн очиж саналаа өгөх боломжгүй сонгогч сонгуулийн хэсгийн хороонд хуульд заасан журмын дагуу хүсэлт гаргаж саналаа өгөх боломжтой.





САНАЛ АВАХ БАЙРАНД ОЧИЖ САНАЛАА ӨГӨХ

Сонгогч саналаа өгөх дарааллыг Монгол Улсын Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд зохицуулсан байдаг.



Санал авах ажиллагаа 2024 он 6 дугаар сарын 28-ний өдөр Улаанбаатарын цагаар өглөөний **07:00 ЦАГААС ОРОЙН 22:00 ЦАГ ХҮРТЭЛ** үргэлжилнэ.



Сонгогч өөрийн байнга оршин суугаа газрынхаа харьяа хэсэгт санал өгөх ёстой. Улсын бүртгэлийн ерөнхий газрын WWW.ELECTION.BURTGEL.GOV.MN цахим сангаас өөрийн бүртгэл болон санал өгөх байрны хаяг, байршлыг харах боломжтой.



Санал авах байранд иргэний үнэмлэхтэй ирж, саналаа биечлэн өгөх бөгөөд сонгогч саналын хуудсанд бичигдсэн зааврын дагуу тэмдэглэгээ хийж саналаа өгнө. Гарын хурууны хээгээр нь сонгогчийг баталгаажуулж, саналын хуудас олгох бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсэг зуруулна. Хэрэв гарын хурууны хээгээр нь сонгогчийг таних боломжгүй бол сонгогчийн иргэний үнэмлэхийн мэдээллийг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган шалгаж, сонгогчийн бүртгэлийн хуудас олгох юм.



Сонгогч санал бэлтгэх бүхээгт нууцаар саналаа тэмдэглэнэ. Сонгогч саналаа тэмдэглэхдээ та өөрийн нутаг дэвсгэр дэх тойрогт ногдсон мандатын тоотой тэнцүү дугуйлна. Мөн нам эвслийн санал тэмдэглэх хэсэгт 1 нам, эвсэлд саналаа тэмдэглэнэ.



Хэсгийн хорооны дарга, гишүүд болон холбогдох бусад этгээд сонгогчийн саналын нууцлалыг алдагдуулахыг хориглодог. Сонгогч саналаа тэмдэглэсний дараа саналын нууцлалыг хангах зориулалт бүхий хавтас хэрэглэж, саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийнэ. Ингэснээр сонгогчид саналаа өгснийг илэрхийлэх тэмдэглэгээг хэсгийн хорооны ажилтан хийж өгнө. Бэхэн тэмдэглэгээг зөвхөн нэг удаа хийх бөгөөд сонгогч тэмдэглэгээ хийх заавартай танилцах боломжтой.



Сонгогч санал тэмдэглэхдээ алдаа гаргаж, буруу тэмдэглэл хийсэн бол саналын хуудсаа санал тоолох төхөөрөмжид хийхээс өмнө энэ тухайгаа хэсгийн хороонд мэдэгдэж, алдаатай саналын хуудсыг хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч, саналаа өгч болно. Мөн санал тоолох төхөөрөмж саналын хуудсыг таньж уншаагүй бол сонгогч энэ тухайгаа хэсгийн хороонд мэдэгдэж, уг саналын хуудсыг хураалгаж, дахин саналын хуудас авч, саналаа өгч болно.



Санал авах өдрийн 22:00 цагт сонгогчийн бүртгэл зогсох бөгөөд бүртгэлийн хуудсаа 22:00 цагаас өмнө авсан бол сонгогч саналаа өгөх боломжтой.



Санал авах байрыг бэлтгэхдээ харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, санал тэмдэглэх зориулалттай брайль үсэг бүхий хавтас санал авах байр бүрд байхаар зохицуулсан.



Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож, бэлтгэсэн байх шаардлагатай. Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.



Санал авах байранд хяналтын камерыг сонгогч саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэхэд саад учруулахгүйгээр байрлуулна. Эдгээр зохицуулалт нь сонгогчийн саналаа нууцаар өгөх боломжийг хангах юм.

ЗӨӨВРИЙН ХАЙРЦГААР САНАЛАА ӨГӨХ

Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагааг **2024 ОНЫ 6 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР 09:00-20:00 ЦАГТ ОРОН ДАЯАР ЗОХИОН БАЙГУУЛНА.**



САНАЛ АВАХ БАЙРАНД ХУУЛИАР ХОРИГЛОСОН ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТ



Санал авах байранд нэр дэвшигч болон зөвшөөрөлгүй бусад этгээд саналаа өгөхөөс бусад тохиолдолд байхыг хориглоно.



Сонгогч саналын хуудаст саналаа тэмдэглэх үед тухайн сонгогчийн дэргэд өөр хүн байхыг хориглоно. Гэхдээ эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл болон боловсролын түвшнээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн хүнээс туслалцаа авч саналаа өгөх боломжтой.

СОНГОГЧ САНАЛАА ӨГӨХӨД ДАРААХ ЗҮЙЛСИЙГ ХОРИГЛОНО




Тухайн санал авах байранд санал өгөх эрхгүй гэдгээ мэдсээр байж санал өгөх;



Өөр хүний бичиг баримт, хуурамч баримт бичиг ашиглаж санал өгөх, саналаа өгөхийг оролдох;



Тухайн хэсгийн хорооноос олгосноос өөр саналын хуудас ашиглах;



Санал авах байранд гаднаас саналын хуудас авч орох, эсвэл авч гарах;



Саналын хуудсанд тэмдэглэсэн саналаа болон бусад сонгогчийн саналыг баримтжуулан зураг авах, дүрс бичлэг хийх, шууд дамжуулах үйлдэл хийх;



Саналын хуудсанд хийсэн тэмдэглэгээг бусдад харуулах, зориулалтын бус үзгээр санал тэмдэглэх;



Аль нэг нэр дэвшигчийн төлөө санал өгөх, эсвэл өгөхгүй байхаар амлалт авах, мөнгө, эд зүйл шаардах, авах.

Сонгогч зайлшгүй мэдэх бас нэг чухал зүйл бол САНАЛЫН ХУУДАС. Саналын хуудас нь сонгогчоос саналаа илэрхийлэх, сонгуулийн дүн гаргах үндсэн баримт бичиг болдог. Өөрөөр хэлбэл, саналын хуудас нь сонгогчид өгч саналыг тэмдэглүүлээд, саналын хайрцагт хийлгүүлээд, түүнийг нь тоолоод хэн ялсныг нь тооцдог, сонгуулийн дараа тодорхой хугацаагаар хадгалдаг чухал баримт бичиг юм.

Саналын хуудас нь агуулга, бичилт, хэлбэрийн хувьд сонгогчоос саналаа илэрхийлэхэд хялбар, ойлгомжтой байх бөгөөд саналаа хэрхэн тэмдэглэх тухай заавар агуулсан байдаг. Тиймээс саналын хуудсанд тэмдэглэл хийхийн өмнө энэ заавартай сайтар, нямбай танилцаж, ямар нэг алдаа мадаггүй саналаа өгөх боломжтой. Хэрвээ сонгогч алдаа гаргавал тухайн саналын хуудсаа хэсгийн хороонд буцааж өгөөд дахин нэг удаа саналын хуудас авч саналаа өгөх боломжийг хуулиар олгодог.

Сонгогч нэг ч нэр дэвшигчийн төлөө саналаа өгөөгүй бол хэнийг ч дэмжээгүй санал гэж үзэн саналыг тоолохгүй боловч тухайн сонгогчийг санал өгсөн сонгогчдын тоонд оруулан тоолно. Гэхдээ энэ саналын хуудас нь хүчинтэй саналын хуудаст тооцогддог. Энэ нь сонгуулийн саналаа чөлөөтэй илэрхийлэх зарчимд хамаарах юм.

Батлагдсан загвар, шаардлагыг хангаагүй саналын хуудас нь хүчингүй байх бөгөөд хүчингүй саналын хуудсаар санал авах, өгөхийг хориглодог юм шүү. Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хууль бусаар хязгаарлах, сонгогчоос саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулахыг хориглодог.

Сонгогч Та Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасан эрх, эрх чөлөөгөө эдэлж, сонгуульд идэвхтэй оролцон саналаа өгөөрэй.



ХОЛИМОГ ТОГТОЛЦООНД СОНГОГЧДЫН САНАЛ ХАМГИЙН БАГА ГЭЭГДДЭГ

УЛС ТӨР СУДЛААЧ
Б.ЦОЛМОНБАЯР

СОНГУУЛИЙН ХОЛИМОГ ТОГТОЛЦООТОЙ БОЛСОН НЬ СОНГОГЧИЙН САНАЛ ГЭЭГДЭХГҮЙ БАЙХ ДАВУУ ТАЛТАЙ

Сонгуульд оролцож саналаа өгөх нь улс төрийн оролцооны хамгийн чухал хэлбэр. Сонгуульд үл оролцох сонгогчдын хувь нэмэгдэх нь иргэний нийгмийн хөгжил, засаглалын легитимт шинж алдагдахад хүргэдэг. 2020 оны УИХ-ын сонгуулийн ирцийг 1992 онтой харьцуулахад 21.9 хувиар Ерөнхийлөгчийн сонгуулийн ирцийг 1993 онтой харьцуулахад 33.3 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Тэгвэл 2012 оны УИХ-ыг сонгох анхны холимог тогтолцоотой сонгуулийн ирц улсын хэмжээнд хамгийн бага 65.3 хувийн ирцтэй байсан нь шинэ тогтолцооны талаарх мэдлэг мэдээлэл тааруу байсантай холбоотой. 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц 59.3 хувь байсан. Эндээс дүгнэхэд, сонгуулийн тогтолцоо өөрчлөгдсөн үед сонгогчдын ирц оролцоо буурах хандлага ажиглагдаж байна. Сонгуулийн тогтолцоо өөрчлөгдсөнтэй холбогдож саяхан сонгогчдын дунд хийсэн судалгаагаар өмнөх сонгуульд гурван хүний нэр дугуйлах гэж л будилдаг байсан бол энэ удаагийн сонгуульд

20-30 нэр дэвшигчдээс арав хүртэлх мандатын тоог гүйцээж дугуйлах нь хүндрэлтэй байх болов уу гэж дийлэнх нь хариулсан байсан. Нөгөө талаас холимог тогтолцооны давуу тал санал гээгдэхийг багасгадаг. Саналаа өгсөн ч миний дэмжсэн нам, улс төрч сонгогдоогүй гэдэг шалтгаанаар сонгуульд оролцохгүй болчихдог иргэдэд энэ давуу талыг ойлгуулж сурталчлах хэрэгтэй.

Түүнчлэн манай улсын хүн амын 40 гаруй хувийг бүрдүүлдэг залуучуудын сонгуульд саналаа өгөх ирц тун бага байгаад анхаарах ёстой. 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд 18-35 насны залуучуудын ирц 50.1 хувьтай үүн дотор 20-24 насны бүлгийнхэн хамгийн бага ирцтэй байсан байна. Хоёр залуу тутмын нэг нь л саналаа өгдөг гэсэн үг. Нөгөөтэйгөөр, 2012 оны сонгуулийн санал авах өдөр зургаадугаар сарын 28-ны өдөр баасан гариг таарч байсан бол энэ удаагийн сонгууль мөн ижил зургаадугаар сарын 28-нд баасан гаригт болохоор товлогдсон. Баасан гариг ажлын сүүлийн өдөр. Энэ утгаар иргэд сонгогчид амралт, аяллаа голчлон төлөвлөж хот суурин газраас гардаг өдөр. Ийм өдөр санал хураах гэж байгаа нь сонгуулийн ирцэд



АПП-ыг татаж сонгогчдын боловсролыг дээшлүүлэх контент, шинэ мэдээ мэдээллүүдийг авараар.

ялангуяа залуу бүлгийн сонгогчдын ирцэд сөргөөр нөлөөлөх вий гэсэн болгоомжлол байна.

ЗАЛУУЧУУДЫГ СОНГУУЛЬД ОРОЛЦУУЛДАГ БОЛОХЫН ТҮЛД ТЭДНИЙГ СОНСОХ ХЭРЭГТЭЙ

Сонгогчид сонгуульд саналаа өгөхгүй байгаа нь тогтолцооны, сонгогчийн боловсрол харилцан адилгүй зэрэг бусад хувийн олон шалтгаантай холбоотой. Оролцохгүй байх шалтгааныг судалж байж арга хэмжээ авах ёстой. Юун түрүүнд иргэд сонгогчдынхоо улс төрийн боловсролыг дээшлүүлэхэд улс төрийн намууд манлайлж ажиллах ёстой. Улс төрийн нам бол төрд хүний нөөцийг бэлтгэж нийлүүлдэг гол институт. Тиймээс гишүүд дэмжигчид, иргэдэд сонгууль гэж юу болох, яагаад оролцох ёстой юм, оролцохгүй бол ямар үр дагавартай талаар сургалт зөвлөгөө өгч ажиллах хэрэгтэй. Залуучуудын дунд хийсэн фокус бүлгийн ярилцлагын явцад дийлэнх оролцогчид улс төрийн намын дэргэдэх залуучуудын байгууллага, нам клубээс ийм төрлийн сургалтын зар, мэдээлэл авч байгаагүй гэж хариулж байсан нь өнөөдөр манай улс төрийн хүчнүүдийн үйл ажиллагаа дулимаг байгааг харуулж байна. Холимог тогтолцооны давуу тал нь санал гээгдэхийг багасгадаг. Тиймээс энэ тухай иргэд сонгогчдод эртнээс ойлгуулах зохион байгуулалттай ажлыг төрийн бус байгууллага, Сонгуулийн хороо зохион байгуулах шаардлагатай. Мөн сонгогчдын бүлгээс ирцийн талаар тогтмол судалгаа авах, сануулах, саналаа өгч иргэний үүргээ биелүүлсэн гэсэн дижитал аян өрнүүлэх зэрэг нөлөөллийн ажлуудыг өргөжүүлэх хэрэгтэй. Цар тахлын үед 33 орон сонгуулиа хийсэн байдаг. Эдгээр улс санал хураах шинэлэг хэлбэрүүдийг нэвтрүүлсэн. Үүнийг бусад орнууд хэрэгжүүлж хэвших арга хэрэгсэл болсон талаар судалгаануудад дурдсан байдаг. Тухайлбал АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд 22.6 хувь урьдчилан санал хураалт, 36.15 хувь нь сонгуулийн өдөр биечлэн, 41.23 хувь нь шуудангаар саналаа өгч оролцсон байна. Зарим мужуудад томоохон орон сууцны зогсоолын гарц, үйлчилгээний төвүүдийн хүлээлгийн хэсэгт машинаасаа саналаа өгөх хэлбэр ашигласан бөгөөд энэ хэлбэрээр саналаа өгсөн сонгогчдын дөрөвний нэг нь өмнө нь огт саналаа өгч байгаагүй сонгогчид оролцсон байсан. Мөн гар утаснаасаа шууд саналаа өгөх боломжтой санал авах самбаруудыг олон нийтийн газруудад байрлуулдаг хэлбэр бас бий. Тэгэхээр саналаа өгөхөд аль болох сонгогчдод чирэгдэлгүй, технологи ашигласан хэлбэрээр зохион байгуулж байгааг анхаарч манай улс нэвтрүүлж ажиллах шаардлагатай байна.

ЗАЛУУ СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛД ЗОРИУЛСАН БҮТЭЭЛИЙН ХАКАТОН

“Лийд Төгсөгчдийн Холбоо” төрийн бус байгууллага Канадын Элчин сайдын яамны “Канад сангийн орон нутгийн санаачилга” хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр “Шинэ сонгогчийн давлагаа” “Gen-V” төслийг хэрэгжүүлж байгаа. Уг төслийн хүрээнд Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо, НҮБ-н Шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран залуу сонгогчдын боловсролд зориулсан ХАКАТОНЫГ 2024 оны 3 дугаар сарын 29, 30-ны өдөр зохион байгууллаа.

Бүх шатны сонгуульд идэвхтэй оролцох нэмэгдүүлэх, залуусын мэдээ мэдээлэл авдаг суваг, төрлийг тодорхойлох зорилготой ХАКАТОН-д дөрвөн аймаг, Улаанбаатар хотын баг оролцов.

ХАКАТОНЫ СЭДЭВ


- Гадаадад байгаа иргэд саналаа хэрхэн өгөх вэ?
- Мөрийн хөтөлбөр гэж юу вэ?
- Саналын хуудсыг хэрхэн бөглөх вэ?
- Сонгогчийн нэрийн жагсаалт гэж юу вэ?
- Сонгох сонгогдох эрх
- Сонгуулийн холимог тогтолцоо гэж юу?
- Улс төрийн нам гэж юу вэ?
- Ажиглагч гэж хэн бэ?
- Сонгуулийн сурталчилгаа ба анхаарах асуудал
- Автоматжуулсан систем ба хяналтын тооллого

БАГУУДЫН БҮТЭЭЛ

- Увс аймгийн баг гадаад улсад байгаа сонгогчдод зориулсан стори,
- Дархан-Уул аймгийн баг мөрийн хөтөлбөрийг ойлгомжтойгоор хүргэх комик,
- Сүхбаатар дүүргийн баг “Ботго сонгогч”-д зориулсан “Болор ботго” пэйж, “Botgo.info” сайтын хөгжүүлэлт,
- Дорноговь аймгийн баг “Сонгох эрх” комик, мийм,
- Дорнод аймгийн баг сонгох эрх сэдвийн хүрээнд “Шинсо” комик, видео контентоо танилцуулав.

ШАЛГАРУУЛАЛТ

Сонгуулийн ерөнхий хороо, “Лийд төгсөгчдийн холбоо”, Канад сан, НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний газрын төлөөллөөс бүрдсэн шүүгчид дээрх бүтээлүүдийг залуу сонгогчдод зориулсан, шинэлэг, хүртээмжтэй, хэрэгжүүлж болохуйц зэрэг шалгуур үзүүлэлтээр шүүсэн юм. Шүүгчдийн үнэлгээгээр Дорнод аймгийн багийн “Шинсо” комик, контент тэргүүн байр, Сүхбаатар дүүргийн “Ботго сонгогч”-д зориулсан сайт, пэйжийн хөгжүүлэлт дэд байр эзэллээ. Шалгарсан багууд бүтээлээ хөгжүүлж, олны хүртээл болгоход зохион байгуулагчид дэмжлэг үзүүлэх юм.



“Ботго багийн бүтээлээс...”

ЗАЛУУС САНАЛАА ӨГНӨ...



Увс аймгийн 2 дугаар цогцолбор
сургуулийн 12e ангийн сурагч
Ө.ЭНХ-ОТГОН:

Сүүлийн үеийн судалгааг харахад залуу сонгогчдын оролцоо харьцангуй бага байдаг юм билээ. Эсрэгээрээ 40-50 насны сонгогчид идэвхтэй байдаг болохоор нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийн дийлэнх нь тэдэн рүү хандсан байдаг. "Халамжийн бодлого барилаа", "цалин тэтгэвэр нэмнэ гэлээ", "залууст хандсан бодлого алга" гэж шүүмжилдэг. Шүүмжлээд хойш суух биш бид хариуцлагатай, идэвхтэй, оролцоотой байвал нам, эвсэл, нэр дэвшигчид залуусын саналыг авахын тулд мөрийн хөтөлбөрөө бидэнд чиглүүлнэ шүү дээ.

Тэр тусмаа гадаадад байгаа үеийнхээ залуусыг саналаа өгөөч гэж уриалмаар байна. Гадаадад байгаа иргэдийн саналыг авахын тулд маш олон хүн хүч, зардал мөнгө зарцуулж байгаа. Гэтэл судалгаагаар маш цөөн хүн санал өгдөг юм билээ. Орхиод гарсан эх орноо хөгжүүлж, эргээд сэтгэл хангалуун амьдрахын тулд нэг өдрийн зав гаргаад саналаа өгөөрэй. Гадаад улсаас санал өгөхийг "Эх орондоо өглөө" гэж хүлээж аваасай.



МУБИС-ийн харьяа Ерөнхий
боловсролын сургуулийн 12a
ангийн сурагч **Р.НАРАНЗУЛ:**

Сонгуульд санал өгөхийг сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулж дөрвөн жилийн хугацаанд улс орноо удирдах боломж гэж харж байгаа. Тэр сонголт маань бидний амьдралд өдөр бүр нөлөөлнө. Тийм учраас зөвхөн залуус гэлтгүй хүн бүр хариуцлагатай байгаасай. Би шинэ сонгогчийн хувьд залуусаа саналаа өгөөч уриалмаар байна. Мөрийн хөтөлбөртөө ямар бодлого тусгаж, яаж ажиллахаар төлөвлөсөн нь ирэх дөрвөн жилд миний амьдралд нөлөөлнө гэж хандаасай. Өөрийнхөө төлөөллөөр дамжуулж эх орныхоо хөгжилд оролцоно.

Сошиал медиагаар шүүмжлэхээс илүү ямар санаа бодолтой байна, эрх баригчдаас юу хүсэж байна гэдгээ ил тод илэрхийлж, шийдлээ дэвшүүлж байвал нам, эвсэл, нэр дэвшигчид мөрийн хөтөлбөртөө тусгана, цаашлаад улс орны хөгжилд нөлөөлнө гэж боддог.

Нийгмийн сүлжээнд сэтгэгдэл харахад ахимаг насныхан их санал өглөө гээд байдаг. Бид ч гэсэн тэдэн шиг эрхээ эдлээд төлөөллөө сонгоод улсынхаа төлөө эхний үйлдлээ хийе л дээ.





Дорноговь аймгийн 5 дугаар
сургуулийн 12а ангийн сурагч
Д.НАРАНЖАРГАЛ:

Сонгуульд оролцох эрхийг маань Үндсэн хуулиар бататгаад өгчихсөн. Харин саналаа өгөх нь эх орныхоо өмнө хүлээсэн үүрэг гэж ойлгож байгаа. Сонгуулийн насны хоёр сая гаруй хүний дотор миний санал нэгхэн болж тоологдох юм чинь яршиг, дараа л больё гэх хандлага байдаг. Тэгвэл миний ганц саналаар улс орон дутна, би Улсын Их Хурлын гишүүний ажил олгогч гэж итгэж, ажилтнаараа дамжуулж эх орноо хөгжүүлж байна гэж итгэх хэрэгтэй. Энэ итгэл үнэмшлээ үр дүнтэй байлгахын тулд мөрийн хөтөлбөр нь хэрэгжиж болохуйц, үр өгөөжтэй байх талаас нь судалж сонголтоо хийнэ.

Саналаа өгнө, сонгуульд оролцоно гэхээр манай үеийнхний зарим нь "улс төр сонирхож яадаг юм, наадах чинь шал хэрэггүй шүү дээ" гэдэг хандлагатай байдаг. Үеийнх нь хүүхэд, залуус нэгэндээ нөлөөлж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, хандлагыг нь өөрчлөх нь чухал гэж боддог.



Дорнод аймгийн Хан-Уул
сургуулийн 12в ангийн сурагч
Э.УРАНГОО:

Сонгуульд оролцох нь миний ирээдүйдээ оруулж байгаа хувь нэмэр гэж ойлгож байгаа. Бидний ах эгч нар сонгуульд саналаа өгөхгүй байж томчуудыг буруутгаад байдаг. Бүгдээрээ саналаа өгч, томчуудыг хариуцлагатай ажиллахыг шаардах хэрэгтэй. Төгсөх ангийн сурагчид би бол шинэ сонгогчид. Өөрсдийгөө "Шинсо" гэж нэрлээд байгаа.

Өмнөх сонгуулиар гэрт оруулж ирсэн мөрийн хөтөлбөрийг хараад "Энэ амласан ажлаа хийдэг үү" гэж асуухаар ээж маань "заримыг нь л" гэж хариулж байсан. Заримыг нь биш бүгдийг нь биелүүл гэж сонгогч бид шаардах ёстой. Сонгуульд өрсөлдөх нам эвсэл, нэр дэвшигчид бидэнд ойлгомжтой байдлаар мөрийн хөтөлбөр, бодлогоо хүргэхэд анхаараасай. Мөрийн хөтөлбөрийг нь аль болгох ойлгож байж сонголтоо хийнэ. Улмаар 22 насны сонголт маань илүү туршлагатай болно шүү дээ. Тиймээс залуу сонгогч гэж үл тоохгүйгээр мөрийн хөтөлбөр, бодлогоо ойлгомжтой танилцуулаарай гэж хүсье.



МУБИС-ийн харьяа Ерөнхий
боловсролын сургуулийн 12Б
ангийн сурагч **Д.ТЭГШЖАРГАЛ:**

Сонгуульд оролцохыг өөрсдийнхөө ирээдүйг өөрийнхөө сонголтоор бүтээх гэж боддог. Хийх ажилд нь итгэсэн, хүсэж байгаа хүнээ сонгож байж бидний ирээдүй сайхан болно. Залуус руугаа чиглэсэн, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжсэн, хааж боодоггүй, зуун хувь нээлттэй нийгэм байгаасай гэж хүсэж байна. Би ч юм уу, хэн нэгэн хувийн бизнесээ эхлүүлэхэд бүрэн боломжтой нийгэм байгаасай гэж хүсдэг. Хүслээ биелүүлэхийн тулд залуус идэвхтэй, оролцоотой байж бодлогоо төлөөлөгчөөрөө дамжуулж хэрэгжүүлэх боломжоо ашиглаасай.

Залуус руу чиглэсэн бодлогыг мөрийн хөтөлбөртөө тусгасан эсэхийг сайн уншиж, судалж байж саналаа өгнө.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН БАТАЛГААЖУУЛАЛТ, ХЯНАЛТ



Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийг 2011 онд баталж, сонгуулийн үйл ажиллагаанд автоматжуулсан төхөөрөмж ашиглах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Улмаар Улсын Их Хурлын 2012 оны сонгуулиас хойш сонгогчийн санал авах, тоолох болон сонгогчийн бүртгэлийн үйл ажиллагаанд сонгуулийн автоматжуулсан системийг бүрэн нэвтрүүлэн, ашиглаж байна.

Сонгуульд техник хэрэгсэл ашиглах тухай шийдвэрийг Улсын Их Хурлаас гаргадаг. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг, санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмжийг хэрэглэх тухай 2023 оны 113 дугаар тогтоол гарсан.

- Санал тоолох төхөөрөмж нь саналын хуудсыг уншиж зурган мэдээллийг хадгалах бөгөөд ингэхдээ тухайн сонгуулийн дүнгийн мэдээллийг нэгтгэн тайлан болгож гаргадаг. Хэсгийн хороонд ажилласан нам, эсвэл, төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын ажиглагч нарт сонгуулийн дүнгийн биллийг хэвлэж, саналын хуудасны зурган мэдээллийг хуулбарлан өгдөг.
- Санал хураалт дууссаны дараа Мэдээллийн технологийн даамал санал тоолох төхөөрөмжийн дүнг Сонгуулийн төв серверт нэн даруй дамжуулах үүрэгтэй. Төв серверт ирүүлсэн дүнг Сонгуулийн ерөнхий хорооны байранд дэлгэцээр шууд нэгтгэн харуулдаг.
- Сонгуулийн бүх шатны хэсгээс ирүүлсэн биллийн дүн, сонгуулийн төв ирсэн дүн, саналын хуудасны зурган файл гэсэн хөдөлшгүй нотлох баримтуудаар сонгуулийн үйл ажиллагааны найдвартай байдалд хяналт тавих боломжтой байдаг.
- Санал тоолох төхөөрөмж ашиглаж эхэлснээс хойших бүх шатны сонгуулиудад төхөөрөмжид уншигдсан саналын хуудасны дүнг хяналтын тооллого хийж баталгаажуулан ажиллаж байгаа бөгөөд өнөөг хүртэл нэг ч зөрүү гараагүй.

САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖ ГЭЖ ЮУ ВЭ?



Санал тоолох төхөөрөмж гэж сонгогчдын саналыг авах, авсан саналыг тоолох, сонгуулийн дүнг нэгтгэн хадгалах, дамжуулах, баримтжуулах техник хэрэгслийг хэлнэ

САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖ ДАРААХ БАРИМТЫГ ҮЙЛДДЭГ

Саналын хуудас

Өндөр нууцлалтай үнэт цаасаар хийгддэг.

Саналын хуудасны зурган мэдээлэл

Сонгогчийн саналын хуудсыг уншсаны дараа санал тоолох төхөөрөмж өөрийнхөө санах ойд сканнердаж зурган мэдээллэ болгон хадгална.

Санал хураалтын тайлан

Санал хураалт дууссны дараа тухайн хэсгийн хорооны ажилчдад болон ажиглагч нарт дүнгийн тайлан буюу баримтыг хэвлэж өгдөг.



САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖИЙН ТУХАЙ

СЕХорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төв, Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Тагнуулын ерөнхий газрын албан хаагчдаас бүрдсэн **АЖЛЫН ХЭСЭГ** автоматжуулсан системийн хэвийн үйл ажиллагааг **шалган туршиж баталгаажуулан гэрчилгээ олгодог**



Сонгуулийн автоматжуулсан системийг сонгуульд бэлтгэхээс дуусах хүртэл нам эвсэл, нэр дэвшигч, ТББ, ИНБ-ууд **нээлттэй ажигладаг**.

Сонгогч таны САНАЛ "НУУЦ" байх зарчмаа үргэлж хадгалдаг.




БАТАЛГААЖУУЛСАН ПАЦНЫ
САНАЛ АВАХ ҮЕЭР ОФФЛАЙН ГОРИМД АЖИЛЛАДАГ



– ХЭСГИЙН ХОРОО
– АЖИГЛАГЧ НАРТ



– СОНГУУЛИЙН ТӨВ
СЕРВЕРТ ИРСЭН ДҮН



– ХЯНАЛТЫН ТООЛЛОГО
100 %

[саналын хуудасны зураг, дүнгийн тайланг өгдөг]

[Санал хураалтын дараа тусгай сүлжээгээр дүнгээ дамжуулдаг бөгөөд 2016 оноос хойш сонгуулийн урьдчилсан **дүнг** дэлгэцээр **шууд дамжуулж** байна]

[2012 оноос хойш зохион байгуулсан хяналтын тооллогын дүн огт **зөрөөгүй**]



Саналын хуудасны зургийг CD-нд хуулах программ нь файлыг автоматаар хольдог тул санал өгсөн дарааллаар байх боломжгүй гэдэгт ИТГЭЛТЭЙ байгаарай.



Санал тоолох төхөөрөмжийн дүнг өөрчлөх, халдлага хийх ямар ч боломжгүй. Дээрх дараалал, баримтжуулалт, мэдээллийг харж, ИТГЭЛ ҮНЭМШЛЭЭ батлаарай.



САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖИЙГ:



Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төв



Аймаг, дүүргийн сонгуулийн хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн баг



Сонгуулийн хэсгийн хороонд Мэдээллийн технологийн даамал **хариуцан ажилладаг.**


Сонгогч Та өөрийн өгсөн саналдаа ямар ч эргэлзээгүй, итгэлтэй байж болно.



СОНГОГЧ САНАЛАА ӨГСНИЙГ ИЛЭРХИЙЛЭХ БЭХЭН ТЭМДЭГЛЭГЭЭ ХИЙХ ЗААВАР

Санал авах байранд болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгсөн сонгогч бүрийн баруун гарын долоовор хурууны арьс болон хумсны толионы уг хэсгийг оруулан 0,5 см-ээс багагүй урттай байхаар зориулалтын бэхээр зурагт заасны дагуу зөвхөн нэг удаа тэмдэглэгээ хийж, бэх хатсан эсэхийг шалгана.

Зурагт заасны дагуу баруун гарын долоовор хуруунд тэмдэглэгээ хийх боломжгүй тохиолдолд дунд хуруунд гэх мэт боломжтой дараагийн хуруунд тэмдэглэгээ хийнэ. Мөн баруун гарын хуруунд тэмдэглэгээ хийх боломжгүй тохиолдолд зүүн гарын долоовор хуруунд, боломжгүй тохиолдолд дунд хуруунд гэх мэт боломжтой дараагийн хуруунд тэмдэглэгээ хийнэ.



С.ЭНХЖАРГАЛ:**САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖИЙН СИСТЕМ
ОЛОН МӨР ҮЛДЭЭДЭГ САЙН ДИЗАЙНТАЙ ГЭЖ
ГАДААДЫН АЖИГЛАГЧИД ДҮГНЭДЭГ**

-ТӨХӨӨРӨМЖ ОЛОН ДАВХАР МӨР ҮЛДЭЭЖ, ХЯНАХ БОЛОЛЦОО ОЛГОДОГ ТУЛ
ГАРААР ТООЛСНООС Ч БАТАЛГААТАЙ-



*Санал тоолох төхөөрөмжийн туршилт, хяналтын талаар
“МИДАС” ТББ-ын гүйцэтгэх захирал С.Энхжаргалтай ярилцлаа.*

-Сонгуульд санал тоолох автоматжуулсан систем нэвтрүүлснээс хойш та хөндлөнгийн ажиглалт, мониторинг хийж байгаа. Санал тоолох төхөөрөмжийн талаарх дүгнэлтээс яриагаа эхэлье. Ямар нэгэн алдаа мадаг ажиглагдсан уу?

-Яг сонгуулийн тооллогоор миний мэдэхээр нэг л удаа карт цэвэрлэгдээгүй тул өмнөх сонгуулийн дүнтэй давхардаж гарсан тохиолдол байдаг. Тэр нь карт цэвэрлэсэн хүний алдаа байсан. Өөр алдаа гарч байсныг би мэдэхгүй.

Сонгууль бүрийн өмнө хэсгүүд дээр төхөөрөмж хүргэсний дараа хийдэг тестүүд дээр хэд, хэдэн удаа алдаа гарлаа гээд комисс очиж шалгахад нь би хамт очиж байсан.

Гэтэл төхөөрөмжөөс бус тухайн хэсэг дээр ажиллаж байсан намуудын ажиглагч, мэдээллийн даамлын хийсэн санаатай, санамсаргүй алдаанаас үүдэлтэй байсан. Тухайлбал, саналын хуудсыг санаатайгаар дахин уншуулчихаад үр дүн буруу гарлаа гээд олон нийтийг төөрөгдүүлсэн мэдэгдэл хүртэл хийж байсан. Тэр үйл явц нь камерт бичигдсэн байсан. Тестийн үед саналын хуудас хайрцаг руу ордоггүй машин дээр шууд уншуулдаг.

-Өмнөх хяналтын тооллогуудаар төхөөрөмж, гараар тоолсон дүн хоёрт зөрүү гарсан тохиолдол бий юу?

-Хяналтын тооллого гэдгийг гараар давхар тоолж шалгаж байгаа гэдгийг нь сонгуульд ажиглагчаар оролцдог хүмүүсээс бусад нь тэр бүр ойлгодоггүй юм шиг санагддаг.

“

**СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ
ХОРООНЫ ДЭРГЭДЭХ
МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ТӨВИЙН
АЖЛЫН ХЭСЭГ Ч ӨӨРСДӨӨ
ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙГЭЭД
ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛДЭГ.
СОНГУУЛЬД ОРОЛЦОЖ
БАЙГАА НАМ, ЭВСЭЛ, БИЕ
ДААГЧДЫН ТӨЛӨӨЛӨЛ
ТӨДИЙГҮЙ ТББ-УУДАД Ч
ХҮСЭЛТИЙН ДАГУУ ШАЛГАХ
ЭРХ ОЛГОДОГ. СОНГУУЛИЙН
ӨМНӨХ ӨДӨР ХЭСЭГ,
ХЭСЭГ ДЭЭР ТУРШИЛТ
ШАЛГАЛТ ЯВАГДДАГ.
МЯНГА СОНСОХООР НЭГ
ҮЗ ГЭДЭГ ҮГ БАЙДАГ.
ГАДНААС ХАРДАЖ СУУХААР
ӨӨРӨӨ ОЧООД ТЭМТРЭЭД,
ТУРШААД ҮЗЭХЭД БУРУУ
ЮУ БАЙХ ВЭ.**



Төхөөрөмж яаж уншсан бэ гэх мэт цөөн тооны маргаан байсан. Зургийн файл дээр яаж уншсаныг тэмдэглэдэг болсноор ямар ч асуудал гараагүй. Улсын Их Хурлын өмнөх сонгуулиар дэлгэцэд гаргаж харуулах системийн алдаа гарсны улмаас Дарханд дахин хяналтын тооллогыг бүрэн хийсэн шүү дээ. Энд ямар ч зөрүү гараагүй.

Хэвлэл мэдээллийнхэн хяналтын тооллого хэрхэн хийдэг, хяналтын тооллого хийх хэсгийг яаж санамсаргүй байдлаар шодож гаргадгийг тэр бүр мэдээлээд байдаггүй учраас олон нийт мэдэхгүй байж магад. Энэ удаагийн сонгуульд 100 хувь гараар тоолж хяналтын тооллого хийнэ, тэр нь нийтэд ил учраас хардлага сэрдлэгээ нэг тийш болгоход ач холбогдолтой.

-Санал тоолох төхөөрөмж будилаантай, хүссэнээрээ тохируулах, тааруулах боломжтой гэх хардлага бүхий мэдээлэл гардаг. Тийм эрсдэл бий юу. Ер нь хардаад, сэрдээд байгаа хүмүүс туршаад хараад, шалгах боломж байдаг болов уу?

-Мэдээж, төхөөрөмжийн программыг хүн л зохиож байгаа тул хэрхэн тохируулсан, хууль дүрмийн дагуу тоолж байна уу гэж харддаг байх. Манай байгууллага ч гэсэн харддаг учраас л хөндлөнгийн мониторинг хийж байгаа шүү дээ. Ялгаатай нь худлаа хоосон хардах биш тестийн тавил боловсруулаад санамсаргүй байдлаар төхөөрөмж сонгоод шалгадаг.

Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн ажлын хэсэг ч өөрсдөө хяналт, шалгалт хийгээд гэрчилгээжүүлдэг. Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, бие даагчдын төлөөлөл төдийгүй ТББ-уудад ч хүсэлтийн дагуу шалгах эрх олгодог. Сонгуулийн өмнөх өдөр хэсэг, хэсэг дээр туршилт шалгалт явагддаг. Мянга сонсохоор нэг үз гэдэг үг байдаг. Гаднаас хардаж суухаар өөрөө очоод тэмтрээд, туршаад үзэхэд буруу юу байх вэ.

-“Санал тоолох машинаараа автоматаар дүн гаргачихдаг гэсэн. Очиж санал өгөх ямар хэрэг байна” гэж ярих хүнтэй таарч байлаа. Сонгогчийн өгсөн саналыг өөрчлөх эрсдэл бий юу?

-Төхөөрөмжийн хоёр картад зэрэг бичнэ, түүнийгээ CD дээр санамсаргүй байдлаар байршуулж зургийн файлаар хуулж ажиглагчдад өгөх, ажиглагчид гарын үсэг зуруулж баталгаажуулах, мөн хувийг нь хэвлэж өгөх гээд процессын хувьд сонгогчид тэр бүр мэдэхгүй олон давхар мөр үлдээж, хянах бололцоо олгодог тул гар тооллогоос хамаагүй илүү баталгаатай. Минийхээр бол ингэж ярьж байгаа хүмүүс бол зарим нэг улстөрчдийн хууралтад автаж санал өгөх эрхээ эдэлж чадахгүй л гэсэн үг. Тэгээд ч дараа нь хяналтын тооллого хийж, саналын хуудсыг гараар тоолдог шүү дээ.

-Цахилгаан тасалж байгаад төхөөрөмжөөрөө будилаан хутгана гэж бас ярьдаг. Тог тасрахаар буруу тоолно гэж байх уу?

-Цахилгаан тасарвал ажиллуулах жижиг аккумулятор баттерейтэй тул харин ч илүү найдвартай. Цахилгааны эх үүсвэр ажиллаагүй байсан ч хоёр карт дахь мэдээлэл өөрчлөгдөхгүй, байгаа байдлаараа бичигддэг. Сонгогчид анзаарсан бол төхөөрөмж олон лацтай байдаг. Нэг карт нь



санал аваад дууссан хойно ч лацтайгаа төхөөрөмжтэйгөө буцаж ирдэг.

-Хэнд саналаа өгснийг төхөөрөмж гаргаад ирэх боломжтой гэх яриа бий. Регистрийн дугаар нь ч юм уу мэдэх боломж бий юу?

-Сонгогчид эхлээд регистрийн дугаараараа бүртгүүлж саналын хуудас авдаг. Энэ нь тусдаа хэсэг байдаг. Санал тоолох төхөөрөмжтэй огт холбоогүй. Санал өгөхдөө ижил үзгээр тэмдэглэдэг. Өгсөн саналыг зурган файл болгохдоо саналыг нууцлалыг хадгалах үүднээс санамсаргүй байдлаар байршуулдаг. Харин хэнд санал өгч байгаа нам, эвслийн ажиглагч нар л хэдий хол ч барьж яваа саналын хуудасны тэмдэглэсэн байрлалаар тодорхойлчих гээд байдаг тул төхөөрөмж хүртэл авч явахдаа тусгай хавтаст хийдэг. Регистрийн дугаараар хэнд саналаа өгснийг чинь мэднэ гэдэг нь айлгах тактик.

-Сонгогчдын нэрийн жагсаалтыг ашиглаад төхөөрөмжийг тохируулж болно гэх нь ч бий?

-Би өмнө хэлсэнчлэн сонгогчдын нэрийн жагсаалт буюу бүртгэлийн хэсэг санал төхөөрөмж хоёр хоорондоо ямар ч хамааралгүй. Санал өгч үзсэн сонгогч бүхэн мэднэ дээ. Саналын хуудас авснаас хойш таны биеийн байцаалтыг хэн ч шалгадаггүй.

-Гадаадад "хар машин"-аар ингэж луйвардаад, манайд ч тийм эрсдэлтэй гэж ярих ч бий.

-Миний хувьд гадаадын сонгуулийг очиж үзэж, хянаж байгаагүй. Харин луйврын талаар ном уншиж, бичлэг харж л судалдаг. Тэгснээрээ тэр луйврыг яаж шалгах вэ гэж тестийн тавил боловсруулахдаа оруулахыг хичээдэг. Жишээ нь "цагийн бөмбөг" тухайн цагаа болохоор өөрөөр тоолно гэдэг тул төхөөрөмж шалгахдаа сонгуулийн огноо, цагийг оруулж турших гэх мэт. Гадаадын ажиглагчид манай улсын сонгуулийг ажиглахдаа танай систем олон мөр үлдээдэг сайн дизайнтай юм байна гэдэг.

Ер нь санал тоолох төхөөрөмжид бүрэн итгэдэггүй хүмүүс байгаа. Итгүүлэхгүй байх зорилготой хүмүүс ч байгаа. Энэ удаагийн сонгууль нэлээд өвөрмөц тоололт хийгдэх тул хуулийн дагуу 100 хувь гараар хяналтын тооллого хийх

ёстой. Хяналтын тооллогыг очоод ажиглаад, дүгнэлтээ хийх эрх хэн бүхэнд бий байх.

-Сонгуулийн ерөнхий хорооноос ч юм уу өөр нэг байгууллагаас таныг хөндлөнгийн ажиглагчаар томилдог уу?

-“Шударга сонгуулийн төлөө” иргэний нийгмийн сүлжээнээс мэргэжлийн туслалцаа үзүүлээч гэж хандсаны дагуу сайн дурын үндсэн дээр оролцож эхэлсэн. Энэ сүлжээ сонгуулийг шударга явуулахын тулд тал бүрээс нь хөндлөнгийн мониторинг хийж ажилладаг.

-2024 оны ээлжит сонгууль холимог тогтолцоогоор болно. Томсгосон олон мандаттай тойрогт саналын хуудсыг төхөөрөмж унших боломжтой болов уу?

-Машин уншихад асуудал гарахгүй болов уу. Харин сонгогчид сонголтоо хийхэд л их цаг зарцуулах болов уу гэж бодож байна. Тиймээс сонгогчдод хандаж доорх зөвлөмжийг хүргэе.

- Эхний ээлжинд өөрөө сонгогч болж уу гэдгээ Сонгогчдын нэрийн жагсаалтнаас шалгаж, танай хаяг дээр байгаа хүмүүсийн бүртгэл үнэн зөв эсэх, аль тойрог, хэсэгт саналаа өгөхөө <https://election.burtgel.gov.mn/> -ээс мэдэх. Ялангуяа гадаадад байгаа сонгогчид 6 сарын 15-аас өмнө холбогдох элчин сайдын яам, консул, төлөөлөгчдийн газруудад бүртгүүлэх
- Өөрийн тойргийн мандатын тоог мэдэх, өөрөөр хэлбэл хэдэн хүн сонгохоо мэдэх маш чухал. Мандатын тооноос дутуу бол таны санал хүчингүй болох хуулийн заалттай.
- Нэр дэвшигчид, нам эвслийн мөрийн хөтөлбөртэй танилцаж санал өгөх хэсэгт сонголтоо хийхчхээд ирвэл хурдан өгөх

Мандатын тооноос илүү, дутуу, эсвэл ойлгомжгүй тэмдэглэгээтэй бол буцаах учир санал тоолох төхөөрөмжид саналын хуудсыг хүлээж аваад доод хайрцагт унах хүртэл жаахан хүлээх хэрэгтэй.

Ярилцсанд баярлалаа.



САНАЛЫН ХУУДСЫГ 100 ХУВЬ ГАРААР ТООЛЖ, ХЯНАЛТЫН ТООЛЛОГО ХИЙНЭ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар санал авах ажиллагаа дууссаны дараа бүх хэсэгт 100 хувь хяналтын тооллого хийнэ.

Хяналтын тооллогыг тасралтгүй, нээлттэй, ил тод зохион байгуулна



Хяналтын тооллого хийх үйл ажиллагааг нээлттэй зохион байгуулах бөгөөд уг үйл ажиллагаанд сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн ажиглагчдыг оролцуулна. Гадаадын ажиглагч, сонгогч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг ажиглагчаар оролцуулж болно.



Хяналтын тооллогыг нэн даруй эхлүүлж, завсарлагагүйгээр явуулж дуусгана.



Хэсгийн хорооны даргын даалгаснаар аль нэг гишүүн хяналтын тооллого хийсэн тухай тэмдэглэл хөтөлнө.



Хяналтын тооллогын үйл ажиллагааг бүхэлд нь хяналтын камерт тасралтгүй буулгаж баталгаажуулна.

Хяналтын тооллогыг хийх дараалал

- Хяналтын тооллогыг эхлүүлэхээс өмнө санал авах ажиллагаанд ашигласан санал тэмдэглэх зориулалт бүхий үзгийг бүрэн хураан авч, хайрцагт хийж битүүмжлэн лацадна;
- Хэсгийн хорооны гишүүн саналын хайрцгаас саналын хуудсыг нэг нэгээр гаргаж саналын хуудаст хийсэн тэмдэглэгээг ажиглагчдад ил тод /дүрс бичлэг, телевиз, эсхүл дэлгэц, проектор ашиглаж болно/-оор харуулан, нэр дэвшигч, нам эвсэл бүрийн авсан санал тус бүрийг уншиж танилцуулна;
- Хэсгийн хорооны дарга, гишүүн нэр дэвшигч болон нам, эвсэл бүрийн авсан саналыг тухай бүрд нь хяналтын тооллогын хуудаст тэмдэглэнэ;
- Хэсгийн хорооны гишүүн энэ тэмдэглэсэн санал тус бүрийг уншиж танилцуулсан саналын хуудсыг 25 ширхэг тус бүрээр нь тоолж багцална;
- Багц тус бүрийг дугаарлах бөгөөд тухайн багц дахь саналын хуудсыг мөн дугаарлана. Багцын дугаар болон саналын хуудасны дугаарыг нэг дор тэмдэглэнэ. /1-1, 1-2, ... 1-25; 2-1, 2-2, ... 2-25 гэх мэт/;
- Нэр дэвшигч болон нам, эвсэлд өгсөн саналыг багц тус бүрээр дүнг нэгтгэн тэмдэглэл гаргах бөгөөд тухай бүрд нь хяналтын тооллогын дүнгийн нэгтгэлд бүртгэнэ;
- Хэсгийн хорооны дарга саналын хайрцгаас гарсан нийт саналын хуудас /багцалсан/-ны тоо нь тухайн санал авах байранд санал өгсөн сонгогчийн тоотой тохирч буй эсэхийг мэдээлнэ;

Хяналтын тооллогын дүнг мэдээлэх

- Саналын хуудсыг тоолж дууссаны дараа хяналтын тооллогын нэгдсэн дүнг гаргаж, энэ тухай хэсгийн хорооны дарга мэдээлэл хийнэ.
- Хэсгийн хорооны дарга хяналтын тооллого хийсэн дүнг сум, дүүргийн сонгуулийн хороонд нэн даруй мэдээлэх бөгөөд сум, дүүргийн сонгуулийн хороод нь дүнг нэгтгэж, аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хороод нь дүнг нэгтгэж, Сонгуулийн ерөнхий хороонд тус тус нэн даруй мэдээлнэ.

Хяналтын тооллого хийх үйл ажиллагаанд хэвлэл мэдээллийн байгууллага болон сонгогчдын төлөөлөл ажиглагчаар оролцох боломжтой.

“

ХЯНАЛТЫН
ТООЛЛОГО ХИЙХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН
БАЙГУУЛЛАГА БОЛОН
СОНГОГЧДЫН ТӨЛӨӨЛӨЛ
АЖИГЛАГЧААР ОРОЛЦОХ
БОЛОМЖТОЙ.

”



БНСУ-ЫН ПАРЛАМЕНТЫН СОНГУУЛИЙН ЭРГЭН ТОЙРОНД...

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын парламентын 22 дахь удаагийн сонгууль 2024 оны дөрөвдүгээр сарын 10-ны өдөр боллоо.


Парламентын сонгуулиар гадаад улсад байгаа иргэдээс 2024 оны гуравдугаар сарын 27-оос дөрөвдүгээр сарын 1-ний өдрүүдэд, урьдчилсан санал хураалтыг дөрөвдүгээр сарын 5, 6-ны өдөр, бүх нийтийн санал хураалтыг дөрөвдүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан юм. Санал хураалтад оролцохоор 44.28 сая иргэн бүртгүүлснээс 67 хувь буюу 29.66 сая сонгогч санал өгчээ. Сонгогчдын ирц 67 хувь хүрсэн нь сүүлийн 32 жилийн хамгийн дээд амжилт аж. Сонгогчдын идэвх сайн, ирц өндөр байсныг урьдчилсан санал хураалтыг ажлын нэг өдөр, амралтын нэг өдөр авч байхаар хуульчилсантай холбоотой гэж ажиглагчид дүгнэсэн юм.

Санал хураалтын дүнгээр сөрөг хүчин Ардчилсан нам (DP) ялалт байгуулан Үндэсний ассамблейн 300 суудлын 174-г нь авчээ. Харин эрх баригч Ардын хүчний нам (PPP) 109, Хууль зүйн сайд асан Чо Кук тэргүүтэй Солонгосыг сэргээн босгох нам (RBK) 12 суудал авчээ. Тодруулбал, Ардчилсан нам 161 дүүрэгт ялалт байгуулж, дагуул нам болох Ардчилсан эвслээр дамжуулан 13 суудал нэмж авсан байна. Мөн пропорциональ 46 суудлын төлөө улс орон даяарх иргэдийн саналаар эрх баригч болон сөрөг хүчин өрсөлдсөн. Ардын хүчний нам 90 тойрогт ялж, пропорциональ сонгуулийн 19 суудал авсан бол Солонгосын сэргээн босгох нам 12 суудал авсан байна.

БНСУ-ын парламентын ээлжит сонгуулийг Монгол Улс, Казахстан, Пакистан зэрэг 27 улсын 58 төлөөлөгч ажиглалаа.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны Нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир, гадаад харилцааны зөвлөх Ч.Баттөмөр нар БНСУ-ын Үндэсний сонгуулийн хорооны урилгаар парламентын сонгуулийн үйл ажиллагааг ажиглаж, "Сөүл-2024: Сонгуулийн асуудлаарх олон улсын форум"-д оролцов.





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛИЙН
25 ДУГААР ТОЙРГИЙН 9 ДҮГЭЭР ХЭСГИЙН
САНАЛ АВАХ БАЙР

СОНГУУЛЬ
2020 ОНЫ
06 ДУГААР
САРЫН 24-НИЙ
ӨДРИЙН
ЛХАГВА ГАРАГТ
БОЛНО.

СОНГУУЛЬДАА ИДЭВХТЭЙ ОРОЛЦООРОЙ


2024

VI.28 07⁰⁰–22⁰⁰





25 ДУГААР ТОЙРГИЙН 6
САНАЛ АВАХ



Улсын Их Хурлын
2020 оны ээлжит
сонгуулийн гэрэл
зургийн архиваас



МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

Засгийн газрын 11 дүгээр байр
Ж.Самбуугийн гудамж,
Улаанбаатар – 15141, Монгол Улс

Санал хүсэлт хүлээн авах хаяг:
gcm@m-election.mn
(976) -51 262127

UIH.MN
СҮДАЛГААНЫ САН